



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 1-6/625
танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНД

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох “Монгол ардын нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


“Монгол ардын нам”-ын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Дорноговь аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт 28...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

Дорноговь аймгийн Монгол Ардын Намын хорооны
2020 оны 05-р сарын 24-ны өдрийн II хуралдааны
2/27 тогтоолын хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОГОВЬ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Уриа.....

Аймгийн Монгол Ардын Намын XXXIV Бага хурлаас үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвараар тэргүүлэгч аймаг болгох зорилт дэвшүүлж, ойрын жилүүдийн хөгжлийн бодлогыг тодорхойлсон юм.

Аймгийн Монгол Ардын Намын хороо Бага хурлаас дэвшүүлсэн бодлогоо хэрэгжүүлэхээр өнгөрсөн дөрвөн жилүүдийн их бүтээн байгуулалтад суурилан ирэх дөрвөн жилд ажлын байрыг нэмэгдүүлэх, мэдлэгт (инноваци) суурилсан үйлдвэр үйлчилгээний бүтцэд онцлон анхаарч, хүний хөгжил аюулгүй байдлыг хангах зорилтыг агуулсан иргэдийн санал хүсэлт, тооцоо судалгаанд үндэслэгдсэн мөрийн хөтөлбөрийг боловсрууллаа.

Энэхүү мөрийн хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийг ажилтай, орлоготой болгон өрх бүрийн амьжиргааны түвшин дээшилж, ажилгүйдэл буурна гэж үзэж байна.

Мөрийн хөтөлбөрийг гадаад дотоодын хөрөнгө оруулалт, олон улсын төсөл хөтөлбөр төсөв санхүүгийн зөв бодлогоор хангаж их бүтээн байгуулалт өрнүүлэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх тул урьдын адил хэрэгжих бүрэн боломжтой юм.

Аймгийн Монгол Ардын Намын хороо 4 бүлэг 20 дэд хэсэг, 475 заалтаас бүрдсэн мөрийн хөтөлбөрийг сонгогч Таньд толилуулж байна.

НЭГ. АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОДЛОГО

Манай аймаг өнгөрсөн 4 жилд ажлын байрыг 6000 гаруйгаар нэмэгдүүлж, 1500 айлын орон сууц ашиглалтад оруулж, эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын салбарын материаллаг баазыг сайжруулж сургуулийн өмнөх насны хүүхэд цэцэрлэгт бүрэн хамрагддаг боллоо. Аймаг ядуурлын түвшингийн хувьд улсын дунджаас 5,



бүсийн аймгуудаас 2,7 пунктээр доогуур, улсын хэмжээнд ядуурал хамгийн бага таван аймгийн нэг болж чадлаа.

Ирэх 4 жилд амьдралын чанарыг дээшлүүлэх бодлогын хувьд Үндэсний хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүүхэд бүрийг сургууль, цэцэрлэгт хамруулан, ажлын байрыг нэмэгдүүлж, ахмадаа хүндэтгэн, залуу үеэ дэмжиж, өрх бүрийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.

1.1 Ажлын байрыг нэмэгдүүлнэ

- 1.1.1 Улсын болон хувийн хэвшлийн үйлдвэр, үйлчилгээний салбар, төмөр зам ашиглалтад орсноор ажлын байр нэмэгдэнэ.
- 1.1.2 Ажилгүйдлийг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийг дэмжиж, ажил эрхлэлтийн түвшинг тогтмол ахиулна.
- 1.1.3 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр, хариуцлагатай уул уурхай, барилга бусад аж ахуйн нэгжүүдийг төрийн бодлогоор дэмжинэ.
- 1.1.4 “Малжуулах төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, малчдын амьдралын нөхцлийг сайжруулна.
- 1.1.5 Аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа томоохон төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын захиалгат ажил, үйлчилгээг нутгийн бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх бодлого хэрэгжүүлж ажлын байр нэмэгдүүлнэ.
- 1.1.6 Аймгийн нутаг дэвсгэрт ашиглалтад орох үйлдвэрүүдэд шаардагдах хүний нөөцийг мэргэжил олгох сургалтад хамруулж ажлын байраар хангах бодлого барина.
- 1.1.7 Сургууль төгсөгчид, цэргийн албанаас халагдсан залуучуудыг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.8 Төрөөс нийгмийн хамгааллын тогтолцоогоор дамжуулан орлогын дахин хуваарилалтыг хийх бодлогыг орон нутагт зохион байгуулж, үр дүнд хүргэнэ.

1.2 Аз жаргалтай гэр бүл

Гэр бүлийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, Монгол гэр бүлийн үнэт зүйлийг сэргээж, бие биенээ хүндэлдэг, байгаль эх дэлхийдээ ээлтэй, зохистой хэрэглээтэй, хариуцлагатай оролцоог суртчилахад анхаарна.

Нийгмийн сайн сайхны төлөө зарцуулж байгаа төрийн санхүүжилтийн үр шим, өгөөжийг нэмэгдүүлнэ.



- 1.2.1 Хүүхэд хамгааллын асуудлыг нэн тэргүүнд тавьж, эрүүл, аюулгүй амьдрах орчныг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг бүрдүүлэх, хүүхдийн хүчирхийллийн эсрэг холбогдох хуулийн хэрэгжилтийг хангана.
- 1.2.2 Гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлж хамтран ажиллана.
- 1.2.3 Иргэдийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдээллээр хангах, хамгаалах дэд бүтцийг сайжруулах цогц арга хэмжээг авна.
- 1.2.4 Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хуримтлалтай гэр бүлийн тоог нэмэгдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.5 “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.2.6 Хүүхэд хөгжлийн төв, гэр бүлийн зөвлөгөө өгөх төвүүдээр гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулна.
- 1.2.7 Зорилтод бүлгийн өрх болон залуу гэр бүлийг нийтийн орон сууцанд хамруулах, орон сууцных нь нөхцлийг сайжруулахад анхаарч хөнгөлөлттэй зээлд хамруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.3 Ахмад, залуу үе, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих бодлого

1.3.1 Ахмадаа хүндэлж-Ачийг нь санана

- 1.3.1.1 Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилга барина.
- 1.3.1.2 Сайншанд, Алтанширээ, Замын-Үүд, Эрдэнэ, Өргөн сумдад “Ахмадын өргөө” барина.
- 1.3.1.3 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймаг, сумдад баригдах орон сууцанд ахмадуудыг хамруулах бодлогыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.1.4 Ахмад настны хөдөлмөр эрхлэлийг дэмжих бодлого баримтална

1.3.2 Ирээдүйг цогцлуулах залуучуудаа дэмжинэ

- 1.3.2.1 “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилтийг хангах талаар залуучуудын санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.3.2.2 Сайншанд суманд хүүхэд, залуучуудын парк байгуулна.
- 1.3.2.3 Сайншанд, Замын-Үүд сумдад хүүхэд, залуучуудын хөгжлийн төв барина.
- 1.3.2.4 Залуу гэр бүлийг орон сууцтай болоход нь дэмжиж ажиллана.



1.3.2.5 Аймаг, орон нутгаа хөгжүүлэх дэвшилтэт санал, санаачилга (инноваци)-д суурилсан төсөл, хөтөлбөр боловсруулсан залуучууд, баг хамт олныг бодлогоор дэмжинэ.

1.3.2.6 Мал маллах сонирхолтой залуу гэр бүлийг малжуулах төсөлд хамруулна.

1.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ дэмжинэ

1.3.3.1 Иргэдийн Хөгжлийн төвийг түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Эрүүлжин боловсрох, хөгжих” төв байгуулна.

1.3.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.

1.3.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сувилал ажиллуулах нөхцлийг бүрдүүлнэ.

1.3.3.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гадаад дотоодын их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.3.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг мэргэжил олгох сургалтад хамруулж, ажлын байртай болгоход дэмжлэг үзүүлнэ.

1.4 Эрүүл мэнд спорт-Амьдралын баталгаа

1.4.1 Нэгдсэн эмнэлгийг компьютер томографик болон орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр шат дараалан хангаж “Цахим эрүүл мэнд” төсөл хэрэгжүүлнэ.

1.4.2 Нэгдсэн эмнэлэгүүдийн эмэгтэйчүүдийн тасгийн дурангийн мэс заслын өрөөг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж сумын төрөх тасгуудын техник төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлого барина.

1.4.3 Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг стандартад заагдсан эмнэлгийн багаж хэрэгслээр хангаж, иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг сайжруулна.

1.4.4 Эх нялхсын эрүүл мэндийн сувилал, асаргааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг бодлогоор дэмжинэ.

1.4.5 Аймгийн хэмжээнд эх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж, эхийн эндэгдэлгүй ажиллан “Эх хүүхдэд ээлтэй эмнэлэг” болох хөдөлгөөнийг өрнүүлнэ.

1.4.6 Эх нярайн тусламжид алсын зайн оношилгооны ашиглалтыг нэмэгдүүлж хүндрэл эндэгдлээс сэргийлнэ.



- 1.4.7 Орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник технологи бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүдийг дэмжиж ажиллана.
- 1.4.8 Аймгийн хэмжээнд “Эрүүл иргэн” аяныг өрнүүлж халдварт болон халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийн тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.4.9 Сайншанд суманд 60 ортой хүүхдийн эмнэлэг шинээр барина.
- 1.4.10 Сайншанд суманд халдварт, сүрьеэгийн эмнэлгийг шинээр барина.
- 1.4.11 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй улс орон болон дотоодын сургалтад хамруулж, нарийн мэргэжил эзэмшигчдийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжоор хангана.
- 1.4.12 Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ сумдад эрүүл мэндийн төвийн барилга шинээр барьж, Сайхандулаан, Хатанбулаг сумын эрүүл мэндийн төвийн барилгад өргөтгөл, зарим багт өрхийн эмнэлэг барина.
- 1.4.13 АШУҮИС-ийн Дорноговь салбар сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийг барина.
- 1.4.14 Уламжлалт анагаах ухааны эмнэлэг барина.
- 1.4.15 “Монгол хүний удмын санг хамгаалах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4.16 Үндэсний өв соёл, спортыг хөгжүүлэх “МОНГОЛ БАХАРХАЛ” төв байгуулна.
- 1.4.17 Спортын материаллаг баазад түшиглэн их спортын төрлүүдээр улс тив, дэлхий, олимпод оролцох тамирчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.18 Сайншанд, Замын-Үүд сумдад стандартын шаардлага хангасан хөл бөмбөгийн болон граундгольфын талбай байгуулна.
- 1.4.19 Сайншанд суманд “Буудлагын тир” байгуулна.
- 1.4.20 Зарим сумдад “Соёл спортын цогцолбор” барина.

1.5 Боловсрол мэдлэг-Хөгжлийн түлхүүр

- 1.5.1 Монгол хэл, түүх, ёс заншил соёлоо мэддэг, эх орноороо бахархдаг, төлөвшсөн ухаалаг иргэдийг бэлтгэх шаталсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5.2 Цэцэрлэгийг 2 ээлжийн багштай болгоно.
- 1.5.3 Сургууль бүрийг сэтгэл зүйчтэй болгоно.
- 1.5.4 Аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын барилгыг шинээр барина.
- 1.5.5 “Багш нарын мэргэжил, боловсролыг дээшлүүлэхээр орчин үеийн сургалтын шаардлагыг хангасан “Багш хөгжил” төв байгуулна.



- 1.5.6 Сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамарсан амжилтыг цаашид бататган сурагчдыг Ерөнхий Боловсролын сургуульд бүрэн хамруулах бодлого барина.
- 1.5.7 Мэдээллийн технологид тулгуурласан танхимын бус онлайн сургалтын системийн тогтолцоог нэвтрүүлнэ.
- 1.5.8 Замын-Үүд суманд 1500, Сайншанд суманд 960, Хатанбулаг суманд 540, Хөвсгөл суманд 320 хүүхдийн сургууль барина
- 1.5.9 Сайншанд сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн барилгад их засвар хийнэ.
- 1.5.10 Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг коллеж болгох боломжийг судалж хэрэгжүүлнэ
- 1.5.11 Аймгийн төвд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Төмөр замын дээд сургууль, бусад их, дээд сургуулиудын салбар байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 1.5.12 Өсвөр үе, залуучуудын насан туршийн боловсролын хэрэгцээнд тохирсон хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5.13 Аймгийн хүүхдийн зуслан шинээр байгуулна.
- 1.5.14 Хүүхдийн ордны дэргэд “Урлан бүтээх төв” байгуулна
- 1.5.15 Ерөнхий Боловсролын Сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинг камержуулж, хүүхэд хамгаалал, эрсдэлээ урьдчилан сэргийлэх нөхцлийг сайжруулж, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд эх, эцэг, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.5.16 Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн түвшинг тогтоон “Миний Монгол-2025” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5.17 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, боловсрох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн барилгын зурагт стандартад нийцсэн орц, гарц, ариун, хэврийн байгууламжийг оруулан сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана.

1.6 Соёл урлаг, үнэт баялаг

- 1.6.1 Орон нутгийн түүх, соёлыг илэрхийлсэн бүтээл туурвих, оюуны үнэт өв, бүтээлийг олон нийтэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлнэ.
- 1.6.2 Соёлын биет болон биет бус өвийг олж тогтоон, бүртгэн баримтлуулж хамгаалалтад авна



- 1.6.3 Аймгийн төвд 800 хүний суудалтай “Сарагжөхөө” шинэ театр барина.
- 1.6.4 Аймгийн орон нутгийн музейг Сайншанд суманд барина.
- 1.6.5 Дорноговь аймгийн Төв номын сан, Төрийн архивын тасгийн нэгдсэн барилга барина.
- 1.6.6 Замын-Үүд суманд соёл урлагийн хөгжлийн төв болон кино театр барина
- 1.6.7 Иргэдэд мэргэжлийн урлагийн шилдэг бүтээл, соёл, урлагийн чанартай үйлчилгээг хүргэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.

ХОЁР. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Өнгөрсөн 4 жилд аймгийн мал сүрэг 2,4 сая, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 198.1 тэрбум төгрөг, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2016 оноос 1,2 сая төгрөгөөр нэмэгдэн аймгийн өрсөлдөх чадвар ахиж 2018, 2019 онуудад Монгол Улсын “Шилдэг аймаг” боллоо. Сайншанд, Замын-Үүд сумдад нар болон салхины сэргээгдэх эрчим хүчний станцууд ашиглалтад орлоо. Бүх сум байнгын цахилгаантай болж, нэгдсэн шугам сүлжээнд холбох ажил эрчимтэй хийгдэж, аймгийн нийт өрх төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчээр хангагдаж ая тухтай амьдрах нөхцөл бүрдлээ.

Ирэх 4 жилд аймгийн дэд бүтэц, хөдөөгийн хөгжилд онцлон анхаарч, эрүүл малтай аймаг болох, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, мэдлэгт суурилсан хөнгөн хүнсний үйлдвэрүүд барин мал аж ахуйн бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийж, нэмүү өртөг шингээн зах зээлд гаргах, баялаг бүтээгчдэд таатай орчин бүрдүүлэх зэрэг олон томоохон зорилтууд хэрэгжинэ.

2.1 Үр ашигтай төсөв-Олон нийтийн оролцоо

- 2.1.1 Төсвийн тогтвортой байдлыг хангах, цахим, ил тод, үр ашигтай байх зарчимд суурилсан төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.2 Төсвийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, бүтээн байгуулалтын хөгжлийг түргэтгэхэд чиглүүлэн үр ашигтай, хариуцлагатай төсөв санхүүгийн зөв зохистой бодлогоор удирдана.
- 2.1.3 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг цахимжуулах замаар иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэн үр ашгийг сайжруулна



2.1.4 Орон нутгийн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг хэрэгжүүлж, олон нийтийн хяналт, оролцоог сайжруулна.

2.1.5 Хөрөнгийн зах зээлийг иргэндээ ээлтэй, эдийн засагтаа өгөөжтэй байдлаар хөгжүүлж, иргэдийн худалдан авах чадварыг нэмэгдүүлнэ.

2.2 Жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого

2.2.1 Аймагт баригдаж байгаа төмөр хайлуур, ган ширэм боловсруулах болон коксын үйлдвэрийн барилгын ажлыг дуусгахад дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана

2.2.2 Усны аж ахуйн агентлагтай хамтарч “Бор хөөвөр”-ийн говьд судалгаа хийж “Усны цөөрөм” байгуулах ажлыг эхлэнэ

2.2.3 Аймагийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн үйлдвэрүүдийг дэмжиж, орон нутгийн компаниудыг туслан гүйцэтгэгчээр ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.2.4 Байгаль орчинд ээлтэй, орчин үеийн технологи бүхий үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

2.2.5 Саарал ус ашиглан үйлдвэрлэл явуулах хувийн хэвшлийг бодлогоор дэмжинэ.

2.2.6 Ноосонд анхан шатны боловсруулалт хийдэг үйлдвэр байгуулах хувийн хэвшлийг бодлогоор дэмжинэ

2.2.7 Оёдлын үйлдвэр байгуулах хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.

2.2.8 Дэвшилтэт технологид суурилсан, эко бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнсний үйлдвэрийг төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна

2.2.9 Ухаалаг технологи нэвтрүүлж ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

2.2.10 “Нутгийн бренд” төв байгуулж иргэн аж ахуйн нэгж, хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг суртчилах, борлуулах нөхцлийг бүрдүүлж, бизнесийн үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.

2.3 Дэд бүтэц-Хөгжлийн тулгуур

2.3.1 Сайншанд суманд дулааны станц барина.

2.3.2 Сайншанд сумын дулааны шугам сүлжээг хоёрдогч хэлхээнд шилжүүлнэ.

2.3.3 Сайншанд сумын Улаанбаатар Төмөр Замын инженерийн шугам сүлжээг орон нутгийн өмчид шилжүүлнэ



- 2.3.4 Сайншанд-Хамарын хийд чиглэлийн авто замыг засварлаж, Зүүнбаян хүртэлх 16 км хатуу хучилттай авто зам шинээр барина.
- 2.3.5 Замын-Үүдийн авто замын хилийн боомтын үйл ажиллагааг 3-4 цаг уртасгах боломжийг судалж хэрэгжүүлэх
- 2.3.6 Сумдыг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замтай холбох техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 2.3.7 Зарим сумдыг цахилгааны шөнийн тарифт шилжүүлэх боломжийг судална
- 2.3.8 Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.9 Сайншанд сумын төвийн авто замыг өргөтгөх ажлыг үе шаттайгаар барина
- 2.3.10 Хатанбулаг-Ханги чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж Ханги тосгоныг байнгын эрчим хүчээр хангана
- 2.3.11 Сайншанд-Зүүнбаян чиглэлийн хүнд даацын авто зам барина
- 2.3.12 Замын-Үүд суманд авто тээврийн үйлчилгээний төв барина
- 2.3.13 Засаг Чандмань уурхайгаас Дэлгэрэх сум хүртэл 16 км газарт 110 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барина
- 2.3.14 Эрдэнэ сумын "Бүрдэнэ" бөөрний суьилалыг босоо тэнхлэгийн авто замтай сайжруулсан замаар холбоно.
- 2.3.15 Эрдэнэ сумыг Өргөн сумтай 10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбоно

2.4 Хот, суурин газрын хөгжил - Орон сууцжуулах бодлого

- 2.4.1 Зарим сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах буюу өөрчлөлт оруулна
- 2.4.2 "Утаагүй Сайншанд" төсөл хэрэгжүүлж, сайжруулсан түлшийг хэрэглээнд нэвтрүүлнэ
- 2.4.3 Сайншанд, Замын-Үүд сумдын суурьшлын бүсэд дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ
- 2.4.4 Сайншанд, Замын-Үүд сумдын гэр хороололд газрыг дахин зохион байгуулах ажлыг үе шаттайгаар хийнэ



- 2.4.5 Сайншанд суманд үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ
- 2.4.5 Зарим сумдад нийтийн үйлчилгээний төв барина
- 2.4.6 Сайншанд суманд “Шинэ Найрамдал” суурьшлын бүс байгуулна
- 2.4.7 Хямд өртөгтэй “Мандах наран” орон сууцны хорооллын хөтөлбөрийг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.4.8 Инженерийн шугам сүлжээнд холбогдсон сумдад орон сууц барина
- 2.4.9 Сайншанд суманд гэр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Тохилог хотхон” орон сууц барих хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 2.4.10 Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.4.11 Сайншанд, Замын-Үүдийн гэр хороолол, сумдын төвд “Тэгш гудамж” болон “Эко жорлон” төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ
- 2.4.12 Сайншанд, Замын-Үүд сумдын гэр хорооллын бүсэд авто зам шинээр барина
- 2.4.13 Иргэдийн шинээр өмчилсөн газарт дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ
- 2.4.14 Сайншанд суманд худалдаа үйлчилгээний задгай зах байгуулна
- 2.4.15 Сайншанд, Замын-Үүд сумдад нийтийн орон сууцнуудыг хариуцсан орон сууц нийтийн аж ахуйн газар (ОСНААГ) шинээр байгуулна.
- 2.4.16 Сайншанд суманд ундны усны нөөцийн санг нэмэгдүүлнэ
- 2.4.17 Аймгийн төвийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ
- 2.4.18 Хуучны орон сууцнуудын инженерийн шугам сүлжээг шинэчилнэ
- 2.4.19 Аймгийн төвийн хуурай, халуун агаарыг чийгшүүлэх “Shand River” хиймэл горхи бүхий ногоон төгөл төслийг эхлүүлнэ
- 2.4.20 Сайншанд суманд “Shand resort” мөсөн гулгуурын талбайг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулна.
- 2.4.21 Цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг дахин ашиглах шугам, хоолойг татаж эдийн засгийн эргэлтэд оруулна
- 2.4.22 “Хашаандаа сайхан амьдаръя” санаачлагын хүрээнд гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 2.4.23 Айраг суманд ундны усны нөөцийн сан шинээр барина
- 2.4.24 Мандах сумын төвд төвлөрсөн халаалт, цэвэр бохир усны шугам барина



2.4.25 Даланжаргалан сумын төвд цэвэрлэх байгууламж бариж, Айраг, Иххэт, Өргөн сумдын цэвэрлэх байгууламжид техникийн шинэчлэлт хийнэ

2.5 Хөдөө аж ахуй-Тэргүүлэх салбар

- 2.5.1 “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Монгол мал” хөтөлбөр, “Атар-4” аяныг орон нутагт үр нөлөөтэй хэрэгжүүлнэ
- 2.5.2 Мал сүргээ чанаржуулах, ашиг шимийг нэмэгдүүлэх малчдын санаачилгыг дэмжиж, нийт мал сүрэгт цэвэр эрлийз болон сайжруулсан нутгийн үүлдрийн малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ
- 2.5.3 “Мал эрүүлжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, “Эрүүл малтай аймаг” болох зорилт дэвшүүлнэ
- 2.5.4 Бэлчээрийн төлөв байдлын үнэмлэхүйтэй хийж, бэлчээрийг зохистой ашиглахаар бэлчээрийн менежмент төсөй хэрэгжүүлнэ
- 2.5.5 Хадлангийн талбай бүхий сумдад хувийн хэвшилд тулгуурлан хадлангийн механикжсан салаа байгуулах санаачлагыг дэмжинэ
- 2.5.6 Алтанширээ, Хөвсгөл, Мандах сумдын өвсний фондыг түшиглэн малын тэжээл бэлтгэх цех байгуулах хувийн хэвшлийн санаачлагыг дэмжинэ
- 2.5.7 “Ус чандмань эрдэнэ” хөтөлбөр боловсруулан усны бодлогыг тодорхойлж, төв суурин болон малчдын ундны усны болон бэлчээрийн усны хангамжийг үе шаттай нэмэгдүүлнэ
- 2.5.8 Сүүний чиглэлийн үхрийн механикжсан ферм байгуулах хувийн хэвшлийн санаачлагыг дэмжинэ
- 2.5.9 Алтанширээ сумын нутаг “Хамар хөөвөр”-т инженерийн хийцтэй услалтын систем байгуулж, малын тэжээлийн ургамал тариалах хувийн хэвшлийн саналыг дэмжинэ
- 2.5.10 “Ингэний ферм” байгуулах нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжинэ
- 2.5.11 Сумдад мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний жишиг нэгжийг байгуулна
- 2.5.12 Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хувийн хэвшлийн санаачлагыг дэмжинэ
- 2.5.14 Аймгийн мал эмнэлгийн газарт Сорилтын лабораторын стандартад нийцсэн лаборатори шинээр байгуулна
- 2.5.15 Цагаан цав, Далантүрүү, Эрдэнэ сумын 18-ын худаг, Хүйтний булагт сум дундын агропарк байгуулна



- 2.5.16 Атарын 4-р аяны хүрээнд аймгийн хэрэгцээт төмс, хүнсний ногооны тодорхой хувийг хангадаг болно
- 2.5.17 Сайншанд суманд жимс, жимсгэнэ, нарийн ногоо тариалах дөрвөн улирлын хүлэмж байгуулах хувийн хэвшлийн санаачлагыг дэмжинэ
- 2.5.19 Аж ахуйн нэгж, айл өрхөд гахай, тахиа, шувуу үржүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.
- 2.5.20 Дэлгэрэх суманд үржлийн улаан ямааны ферм байгуулна
- 2.5.21 Замын-Үүд сум дахь “Мал эрүүлжүүлэх, нядлах, боловсруулах” үйлдвэрийг ашиглан мах экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.5.22 Сайншанд, Замын-Үүд сумдад төмс, хүнсний ногооны механикжсан зоорь барина
- 2.5.23 Мал нядлах болон мах боловсруулах үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн санаачлагыг дэмжиж, нөөцийн махыг бүрдүүлнэ.
- 2.5.24 Замын-Үүд суманд худалдаа үйлчилгээний нэгдсэн төв барина

2.6 Хөдөөгийн хөгжил-Бидний бахархал

- 2.6.1 Сумдын төвийн инженерийн нэгдсэн шугам, сүлжээний барилга байгууламжийг дуусгаж, ашиглалтад нь хяналт тавьж иргэдийг сумандаа сайхан амьдрах нөхцөл боломжоор бүрэн хангана.
- 2.6.2 Сумдад хоршоог түшиглэн хөдөө аж ахуйн бирж ажиллуулж, малчдад жуулчлах оновчтой хэлбэрийг дэмжинэ
- 2.6.3 Алслагдсан бүс нутагт үүрэн холбооны сүлжээг нэвтрүүлнэ
- 2.6.4 Байгалийн эрсдлээс урьдчилан сэргийлэх цаг агаарын мэдээллийн хүртээмжийг сайжруулна
- 2.6.5 Малчдад төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.7 Сумандаа сайхан амьдарья

Нэг. Айраг суманд

1. Сумын төвийн 4-р багийн нутаг дахь уурхайчдын байшин байрыг дахин төлөвлөлтөд оруулна
2. Сумын төвийн гэр хорооллыг жишиг гудамжтай болгоно
3. Мах боловсруулах үйлдвэр байгуулна

Хоёр. Алтанширээ суманд

1. Иргэдийн хөгжлийн төв барина
2. Сумын төвд соёл спортын цогцолбор барина



3. Нийтийн орон сууц барина
4. Мах боловсруулах үйлдвэр байгуулна

Гурав. Даланжаргалан суманд

1. Сумын дотуур байрны барилгыг засварлаж багш ажилчдын орон сууц болгоно
2. Сумын төв, Олон-Овоо багийн хогийн цэгийг хашаажуулна
3. Олон-Овоо багт өрхийн эмнэлэг шинээр барина
4. Олон-Овоо багт соёлын төвийн барилга шинээр барина
5. Олон-Овоо багт цэвэрлэх байгууламж барих ажлыг судалж шийдвэрлэх
6. Нийтийн орон сууц барина

Дөрөв. Дэлгэрэх суманд

1. Цаг уурын станцын барилга шинээр барина
2. Соёлын төвийн барилга шинээр барина
3. Нийтийн үйлчилгээний төв байгуулна
4. Нийтийн орон сууц барина
5. Сайжруулсан шороон зам тавина

Тав. Замын-Үүд суманд

1. Сумын төвийн гэр хорооллын дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ
2. Сумын төвд гэрэлтүүлэг, камержуулалт тавигдана
3. Замын-Үүд суманд 1000 м/кубын багтаамжтай усан сан, шахуурга станцын хамт шинээр барина
4. Борхойн наран өрхийн эмнэлэг барина
5. Нийтийн үйлчилгээний төв байгуулна

Зургаа. Иххэт суманд

1. Сумын төвд гэрэлтүүлэг, камержуулалт тавигдана
2. Нийтийн орон сууц барина

Долоо. Мандах суманд

1. Соёл, спортын цогцолбор барина
2. Нийтийн орон сууц барина

Найм. Өргөн суманд

1. Сумын шинэ суурьшлын бүсэд дэд бүтэц барина
2. Мал нядалгааны газар барина



3. Ерөнхий Боловсролын Сургуулийн өргөтгөл хийнэ
4. Нийтийн орон сууц барица

Ес. Сайхандулаан суманд

1. Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл хийнэ
2. Соёлын төвийн барилга шинээр барина
3. Нийтийн үйлчилгээний төв байгуулна

Арав. Сайншанд суманд:

1. “Эрүүл, Ухаалаг хот-Сайншанд” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
2. “Шинэ Найрамдал” суурьшлын бүс байгуулна.
3. Хямд өртөгтэй “Мандах наран” орон сууцны хорооллын хөтөлбөрийг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ
4. “Түрээсийн орон сууц” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Тохилог хотхон” орон сууц барих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
6. “Утаагүй Сайншанд” төсөв хэрэгжүүлж, сайжруулсан түлшийг хэрэглээнд нэвтрүүлнэ.
7. Суурьшлын бүсэд дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хийнэ.
8. Гэр хороололд газрыг дахин зохион байгуулах ажлыг үе шаттайгаар хийнэ
9. “Унадаг дугуй” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
10. Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ.
11. Гэр хорооллын бүсэд авто зам шинээр барина.
12. Иргэдийн шинээр өмчилсөн газарт дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
13. Худалдаа үйлчилгээний задгай зах байгуулна.
14. Нийтийн орон сууцнуудыг хариудсан орон сууц нийтийн аж ахуйн газар (ОСНААГ) шинээр байгуулна.
15. Ундны усны нөөцийн санг нэмэгдүүлнэ.
16. Гэр хорооллын цахилгаан шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
17. Хуучны орон сууцнуудын инженерийн шугам сүлжээг шинэчилнэ.
18. Аймгийн төвийн хуурай, халуун агаарыг чийгшүүлэх “Shand River” хиймэл горхи бүхий ногоон төгөл төслийг эхлүүлнэ.



19. "Shand resort" мөсөн гулгуурын талбайг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулна.
 20. Цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг дахин ашиглах шугам, хоолойг татаж эдийн засгийн эргэлтэд оруулна.
 21. "Хашаандаа сайн амьдаръя" санаачлагын хүрээнд гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
 22. Мах боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулна.
 23. Мал нядалгааны төвлөрсөн цэгийг байгуулна.
 24. Нийтийн орон сууцныг орчны тохижилтыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 25. Усан оргилуур, ногоон байгууламж бүхий нийтийн эзэмшлийн талбайг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 26. "Sainshand garden" төв цэцэрлэгт хүрээлэнг шинэчлэн тохижуулна.
 27. Хотын нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн орон сууц, гэр хорооллын гудамжыг камержуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 28. Хотын төвийн болон гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 29. "Тэгш гудамж" төслийг хэрэгжүүлнэ.
 30. Мал бүхий иргэдийг төв суурингаас шилжүүлж, мал аж ахуйн бүсийг бий болгоно.
 31. Газар тариалангийн бүсийн дэд бүтцийг шийдвэрлэнэ.
 32. Малчдад бэлчээрийн худаг шинээр гаргаж, хуучин худгуудыг сэргээн засварлана.
 33. Сумын төвийн ундны усанд цэнгэгшүүлэх төхөөрөмж суурилуулж ухуулаг систем нэвтрүүлнэ.
 34. Хамарын хийдийн дөрвөн замын уулзвар дахь "Хилэнцийн хөшөө" орчимд цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- 1 дүгээр баг
- 1 Иргэдийн шинээр өмчилсөн газарт дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
 - 2 Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 - 3 "Тэгш гудамж" төслийг хэрэгжүүлнэ.
 - 4 Шаардлагатай хэсэгт Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг хийнэ.



- 5 Нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн орон сууц, гэр хорооллын гудамжыг камержуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 - 6 Нийтийн орон сууцны байрнуудын орчимд хог ангилан ялгах савыг байршуулна.
 - 7 Гэр хорооллын айл өрхүүдэд хог ангилан ялгах савыг байршуулна.
 - 8 Нийтийн орон сууцнуудад “Манай орц” төслийг хэрэгжүүлнэ.
 - 9 Гэр хорооллын авто замын дагуу явган хүний зам, дугуйн зам шинээр барина.
 - 10 Суурьшлын бүсэд дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хийнэ.
 - 11 6 Баатарын хөшөөний хойд талын авто замаас 14-р цэцэрлэг, Далай Сайншанд хөтөлийн чиглэлд авто замыг үргэлжлүүлэн тавина.
 - 12 24 яслийн зогсоол, 6 баатарын зогсоолыг түшиглэн автобусны буудал байгуулна.
 - 13 Данзанваанчигийн 7-р хэсэгт байрлах тоглоомын талбайг өргөтгөж, шинэчилнэ.
 - 14 Аюушын 1-р хэсгийн айл өрхүүдийг бохирын төвлөрсөн цооногт холбоно.
 - 15 Ноён хутагтын 30, 31-р байрны гаднах авто зам, зогсоолыг шинэчилнэ.
 - 16 Дэчинчойнхорлин хийдийн гадна авто зогсоол шинээр барина.
 - 17 Данзанваанчигийн 10-р хэсэгт тоглоомын талбай шинээр байгуулна.
 - 18 Шинэ зууны 132, 133-р байр, 8 цэцэрлэгийн орчимд авто зам шинээр тавина.
 - 19 ЕБ-ын 2-р сургуулийн зүүн талын авто зам, Монос эмийн сангийн уулзвартай холбоно.
 - 20 Данзанваанчигийн 7-р хэсэгт ухаалаг худаг шинээр байгуулна.
 - 21 “Далай Сайншанд” ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
 - 22 Шинэ зууны 33, 34-р байрны гаднах авто зам зогсоолыг шинэчилнэ.
 - 23 Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ.
 - 24 Гэр хороололд “Эко жорлон” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2 дугаар баг
1. Иргэдийн шинээр өмчилсөн газарт дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
 - 2 Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 - 3 “Тэгш гудамж” төслийг хэрэгжүүлнэ.
 - 4 Шаардлагатай хэсэгт гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг хийнэ.
 - 5 Нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн орон сууц, гэр хорооллын гудамжийг камержуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.



- 6 Нийтийн орон сууцны байрнуудын орчимд хог ангилаан ялгах савыг байршуулна.
 - 7 Гэр хорооллын айл өрхүүдэд хог ангилаан ялгах савыг байршуулна.
 - 9 Нийтийн орон сууцнуудад “Манай орц” төслийг хэрэгжүүлнэ.
 - 9 Гэр хорооллын авто замын дагуу явган хүний зам, дугуйн зам шинээр барина.
 - 10 Суурьшлын бүсэд дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хийнэ.
 11. Нийтийн орон сууцны орчны тохижилтыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ
 12. Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн баруун уулзвараас Дэнж гудамж 11, 12 дугаар хэсгийн гэр хорооллын бүсийг дамжиж Дэнж гудамж 39 дүгээр байрны баруун талын төв замтай холбогдсон авто зам шинээр барина
 13. Төв дулааны уурын зуухны урд талаас төмөр зам даван хуучнаар усны аж ахуйн зүүн талаар үүссэн олон жилийн хур хог хаягдлыг бүрэн цэвэрлэж газрыг дахин төлөвлөлтөд оруулна
 14. Гэр хороололд “Эко жорлон” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
 15. Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ.
 16. Ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, саарал усыг ашиглан хиймэл гол, цөөрөм байгуулна.
 17. Хуучны насжилттай нийтийн эзэмшлийн талбайд байрлах орон сууцнуудын дулаан, цэвэр, бохирын шугамыг үе шаттайгаар шинэчилнэ.
 18. Газар тариалан, фермерийн мал аж ахуйг дэмжиж усжуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
 19. Шаардлагатай цэгт орчин үеийн стандартад нийцсэн нийтийн тээврийн үйлчилгээний буудал барина.
 20. Чийрэгжүүлэлтийн төхөөрөмж бүхий спортын задгай талбай байгуулна.
- 3 дугаар баг
1. Иргэдийн шинээр өмчилсөн газарт дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
 2. Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 3. “Тэгш гудамж” төслийг хэрэгжүүлнэ.
 4. Шаардлагатай хэсэгт гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг хийнэ.
 5. Нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн орон сууц, гэр хорооллын гудамжыг камержуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.



6. Нийтийн орон сууцны байрнуудын орчимд хог ангилан ялгах савыг байршуулна.
7. Гэр хорооллын айл өрхүүдэд хог ангилан ялгах савыг байршуулна.
8. Нийтийн орон сууцнуудад “Манай эрц” төслийг хэрэгжүүлнэ.
9. Гэр хорооллын авто замын дагуу явган хүний зам, дугуйн зам шинээр барина.
10. Суурьшлын бүсэд дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хийнэ.
11. Нийтийн орон сууцны орчны тохижилтыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
12. Худалдаа үйлчилгээний задгай зах байгуулна.
13. Сумын төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулна
14. Тогоотын байрны 16-р хэсгээрүү овоо давсан явган хүний шат хийнэ
15. Хуучин тоглоомын талбай болон цэцэрлэгт хүрээлэнг сэргээн засварлана
16. Номин худалдааны төвийн хойд уулзвараас зүүн тийш Сод Монголын уулзвар хүртэл авто зам шинээр барина
17. Хуучны орон сууцны инженерийн шугам сүлжээг шинэчилнэ
18. Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ.
19. Гэр хороололд “Эко жорлон” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
20. Төв зам дагуу шаардлагатай хэсгүүдэд автобусны буудал барина.
21. Чийрэгжүүлэлтийн төхөөрөмж бүхий спортын задгай талбай байгуулна.
22. Малчдын хуучин худгийг лайдаж сэргээн засварлана.

• **4 дүгээр баг**

1. 4 багийн нутаг дэвсгэрт Ганзамын 5 байшингаас 3 замын уулзвар цагдаагийн пост хүртэл, 60 гэр, Өндөр дов зэрэгт гэрэлтүүлэг тавина
2. 4-р баг 60 гэр, хуучин эмнэлгийн баруун талаар Ганзамын 154, 34-р байрны баруун талаар авто зам барих
3. Төмөр замын 3 замын уулзвараас Сайншандын дүүжин гүүр хүртэл төв авто замыг өргөтгөж 4 эгнээ болгоно
4. 4-р багийн гэр хорооллын шаардлагатай хэсэгт камер, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
5. Хөлбөмбөгийн талбай байгуулна
6. 4-р баг Ганзамын 76-79-р, 34, 154-р байрнуудын гадна талд автомашины зогсоолтой болгоно
7. 4-р баг Ганзамын 76-79-р байруудыг засварлах
8. Тэгш гудамжтай болох



9. Цэвэр усны шугамыг гэр хорооллын гудамжаар үргэлжлүүлэн тавина
10. 877-р байрнуудын дунд 3*3 сагсан бөмбөгийн талбай байгуулах
11. Ганзамын 84-94 байрнуудын дунд тоглоомын талбай байгуулах
12. Төмөр замд "Ахмадын өргөө" байгуулах
13. 60 гэрийн гудмууд, бага сургуулийн авто замыг үргэлжлүүлэн тавих
14. Дунд буянт-Ухаа, Ганзамын байрнуудын дундах худгийг смарт болгох
15. 60 гэрт автобусны буудал барих
16. 154-р байрны дээвэр, шугам сүлжээг засварлах
17. ББУ, Мандах наран-4 хороололруу эргэсэн 4 замын уулзварт гэрлэн дохио тавих
18. Малчдын бэлчээрийн худаг гаргах
19. УБТЗ-н өмчлөлийн инженерийн шугам сүлжээг орон нутгийн өмчид авах
20. Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ.
21. Гэр хороололд "Эко жорлон" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

• **5 дугаар баг**

1. Иргэдийн шинээр өмчилсөн газарт дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
2. Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
3. "Тэгш гудамж" төслийг хэрэгжүүлнэ.
4. Шаардлагатай хэсэгт гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг хийнэ.
5. Нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн орон сууц, гэр хорооллын гудамжыг камержуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
6. Нийтийн орон сууцны байрнуудын орчимд хог ангилан ялгах савыг байршуулна.
7. Гэр хорооллын айл өрхүүдэд хог ангилан ялгах савыг байршуулна.
8. Нийтийн орон сууцнуудад "Манай орц" төслийг хэрэгжүүлнэ.
9. Гэр хорооллын авто замын дагуу явган хүний зам, дугуйн зам шинээр барина.
10. Суурьшлын бүсэд дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хийнэ.
11. Гэр хороололд "Эко жорлон" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
12. Нийтийн орон сууцны орчны тохижилтыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
13. Зүүнбаянгийн соёлын төвд их засвар хийнэ
14. Сум дундын эмнэлэгийн дээврийг засварлана
15. 78 айлын дээвэр, фасадыг засварлана



16. 8 айлын дээвэр, фасадыг засварлана
 17. Зүүнбаянгийн төвийн авто замыг шинээр барина
 18. "Зүүнбаян" хүүхэд залуучуудын талбайг шинээр байгуулна
 19. 2 дугаар 58 айлыг засварлаж ашиглалтад оруулна
 20. Малчдад бэлчээрийн худаг шинээр гаргаж, хуучин худгийг сэргээн засварлана.
 21. Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ.
- **6 дугаар баг**
1. Иргэдийн шинээр өмчилсөн газарт дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
 2. Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
 3. "Тэгш гудамж" төслийг хэрэгжүүлнэ.
 4. Багийн нутаг дэвсгэрт Камержуулалтыг шинээр хийнэ.
 5. Нийтийн орон сууцны байрнуудын орчимд хог ангилан ялгах савыг байршуулна.
 6. Гэр хорооллын айл өрхүүдэд хог ангилан ялгах савыг байршуулна.
 7. Нийтийн орон сууцнуудад "Манай орц" төслийг хэрэгжүүлнэ.
 8. Гэр хорооллын авто замын дагуу явган хүний зам, дугуйн зам шинээр барина.
 9. Дампилын 15, 16, 17, Жанчивын 20-р хэсгийн Гэр хороололд гэрэлтүүлэг, цамхагт гэрэл суурилуулна.
 10. Шинэ зууны 219, 221-р байрны хойно, Гурван хөвсгөл трейд, Үлэмж, Хулшанд худалдааны төвийн гадна авто зогсоол барина.
 11. Ерөнхий боловсролын 2-р сургуулийн хойд талын 1,7 км авто замыг үргэлжлүүлэн хэсэгчлэн барина.
 12. "My music"-ээс баруун тийш авто замын хоёр талаар явган хүний зам барина.
 13. Дампилын 16, 17, Алтанжолоогийн хэсэгт Үерийн усны далан барина.
 14. Халуун усны уулзвараас Нэгдсэн эмнэлэг хүртэл авто зам шинээр барина.
 15. Гэр хороолол, 1, 2-р 80 айлын авто зогсоолыг камержуулна.
 16. Жанчивын 21-р хэсэг / гахайн байр-г ухаалаг худаг шинээр барина.
 17. Шинэ зууны 80 айлын орчимд ногоон байгууламж бий болгоно.
 18. Суурьшлын бүсэд дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хийнэ.
 19. Дампилын 17, Жанчив 20-р хэсэгт газар дахин зохион байгуулалт хийнэ.
 20. Дампилын 13,14-р хэсэгт "Тэгш гудамж" төсөл хэрэгжүүлнэ.



21. Жанчивын хэсэгт Автобусны буудал барина.
22. Жанчивын худгийг Ухаалаг системд шилжүүлнэ.
23. Ханбаян зүрх хайрханы орчим ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
24. Гэр хороололд "Эко жорлон" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
25. Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ

• 7 дугаар баг

1. СОТ, Найрамдал, Депо байранд хүүхдийн тоглоомын талбай барих
2. 7-р багийн гэр хсрооллын шаардлагатай хэсэгт камер, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
3. Найрамдал, СОТ, Депо байрны шаардлагатай хэсэгт инженерийн шугам сүлжээг холбох, өргөтгөх
4. Нийтийн орон сууцны инженерийн шугамыг шинэчилэх
5. Ганзамын 72, 73, 125, 126, 127, 129, 130 байрнуудын зам талбай, сүүдрэвч барих
6. Мандах наран-4 хороолол, СОТ-н байр, Хараацай цэцэрлэгийн урдуур Депо байрлуу шинээр авто зам тавих, Мандах наран-4 байрны урдуур Депо байр, Депо байрнаас төв авто замтай холбох
7. Мандах наран-4 хороолол, ББУ-руу эргэсэн 4 замын уулзварт гэрлэн дохио тавих
8. Нийтийн орон сууцнуудын орчинд нэгдсэн автомашины граштай болох
9. Депо байр, Найрамдалд автобусны буудал барих
10. Тэгш гудамжтай болох
11. Төмөр замд соёл, спортын ордонтой болох
12. Малчдад бэлчээрийн худаг гаргах
13. 3 замын уулзвараас дүүжин гүүр хүртэл төв замыг 4 эгнээ болгож өргөтгөх
14. 7 дугаар багийн нутаг дэвсгэрт Ганзамын 5 байшингаас 3 замын уулзвар цагдаагийн пост хүртэл гэрэлтүүлэг тавих
15. Спортын талбай байгуулна
16. 7-р баг Ганзамын 72-75-р байруудад засвар хийх
17. УБТЗ-н өмчлөлийн инженерийн шугам сүлжээг орон нутгийн өмчид авах
18. Гэр хороололд "Эко жорлон" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
19. Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ.
20. "Дорноговь-80" цогцолбор танкийн хөшөөг түшиглэн "Эх орончдын талбай" байгуулна.



• 8 дугаар багт

1. Иргэдийн шинээр өмчилсөн газарт дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
2. Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
3. “Тэгш гудамж” төслийг хэрэгжүүлнэ.
4. Шаардлагатай хэсэгт гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг хийнэ.
5. Нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн орон сууц, гэр хорооллын гудамжийг камержуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
6. Нийтийн орон сууцны байрнуудын орчимд хог ангиан ялгах савыг байршуулна.
7. Гэр хорооллын айл өрхүүдэд хог ангиан ялгах савыг байршуулна.
8. Нийтийн орон сууцнуудад “Манай орц” төслийг хэрэгжүүлнэ.
9. Гэр хорооллын авто замын дагуу явган хүний зам, дугуйн зам шинээр барина.
10. Суурьшлын бүсэд дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хийнэ.
11. Залуус хороололын гадна талбайн тохижилт, авто зогсоол барина
12. 51 авто засварын баруун талд “Холбоо” спортын задгай талбай байгуулна
13. Номин худалдааны төвийн хойд уулзвараас зүүн тийш Сод Монголын шатахуун шүгээх станцын уулзвар хүртэл авто зам шинээр барина
14. Үзүүрийн 4 дүгээр гудамжны сагсны талбайг шинэчлэн засварлана
15. Зам дагуух автобусны зогсоолыг шинэчлэнэ
16. Алтанговь-2 гудамжны 233, 245 байрны гадна талбайн тохижилт, авто зогсоол барина
17. Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг нэмэгдүүлнэ.
18. Гэр хороололд “Эко жорлон” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Арван нэг. Улаанбадрах суманд

1. Нийтийн орон сууц барина
2. Үүрэн телефоны дахья дамжуулах станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх

Арван хоёр. Хатанбулаг суманд

1. Биеийн тамир, спортын тоноглол бүхий талбай байгуулна.
2. Сумын төвийн болон Ханги суурьшлын бүсийн гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлнэ
3. Шилэн кабельд холбоно



4. Сумын төв болон Ханги суурьшлын бүсэд нийтийн орон сууц барина
5. Ханги суурьшлын бүсэд мал нядалгааны газар байгуулна

Арван гурав. Хөвсгөл суманд

1. Сумын төвд сайжруулсан зам тавина
2. Шилэн кабельд холбоно
3. Нийтийн орон сууц барина
4. Мах боловсруулах үйлдвэр байгуулна

Арван дөрөв. Эрдэнэ суманд

1. Сумын төвд сайжруулсан зам тавина
2. Соёл, спортын цогцолбор барина

**ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЭКОЛОГИЙН
БОДЛОГО**

Аймаг өнгөрсөн 4 жилд байгалийн унаган төрхийг хадгалж, нөөц баялгаа зөв зохистой ашиглах, аялал жуулчлал хөгжүүлэхэд амжилт боллоо. Айраг сумын “Цагаан дэлийн агуй” Хөвсгөл сумын нутаг “Гүн гашууны хоолой”-г улсын, 9 газрыг аймгийн тусгай хамгаалалтад тус тус авч, Хамарын хийдэд олгогдсон ашиг малтмалын ашиглалтын хоёр тусгай зөвшөөрлийг цуцлууллаа. Одоо аймгийн нийт нутаг дэвсгэрийн 25,9 хувь тусгай хамгаалалтад байна.

Аймагт жилдээ 130-аад мянган гадаад, дотоодын жуулчид ирдэг боллоо. Ирэх 4 жилд улс, аймаг, сумын тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ нэмэгдэж, байгалийн баялгаа зөв зохистой ашиглан аялал, жуулчлалыг аймгийн хөгжлийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлнэ.

3.1 Байгальд ээлтэй хөгжил, иргэнд таатай орчин

- 3.1.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, улсын дундажийн хэмжээнд хүргэнэ
- 3.1.2 Ан амьтдын амьдрах орчныг нь хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ
- 3.1.3 Орон нутагт хийгдэж байгаа дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг ан амьтанд сөрөг нөлөөгүйгээр хийнэ
- 3.1.4 Сайншанд суманд хог дахин боловсруулах үйлдвэр барина



- 3.1.5 Хог хаягдлын менежментийг сайжруулж Сайншанд, Замын-Үүд сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг 2-р зэрэглэл, бусад сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг 3-р зэрэглэлийн шаардлагад хүргэнэ
- 3.1.6 “Ногоон Дорноговь” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
- 3.1.7 Ногоон байгууламж нэмэгдүүлэх, арчилгаа үйлчилгээг сайжруулах ажлыг Ойн анги болон олон нийтийн оролцоонд тулгаарлан төлөвлөлтэйгөөр зохион байгуулна
- 3.1.8 Цэвэрлэх байгууламжийн саарал усны ашиглалтыг сайжруулж, хотын ногоон байгууламжийн усалгаанд ашиглана
- 3.1.9 Сайншанд сумын мод үржүүлгийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж, аймгийн хэмжээний ногоон байгууламжийн хэрэгцээг хангана
- 3.1.10 Уул уурхайн ашиглалтын улмаас орхигдсон талбайд мэргэжлийн байгууллага, олон нийтийн хяналтан дор техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийлгэнэ
- 3.1.11 Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт Ураны ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоож, зөвшөөрлийг цуцлуулах саналыг үргэлжлүүлэн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ
- 3.1.12 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход нутгийн иргэдийн саналд тулгуурлан шийдвэрлэдэг болгох асуудлыг дээд шатны байгууллагад хүргүүлнэ
- 3.1.13 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг дэд бүтэц бий болгосон тохиолдолд тээвэрлэлт хийх зөвшөөрөл олгодог тогтолцоог бий болгоно
- 3.1.14 Булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжүүлж хийнэ
- 3.1.15 Зарим сумдад зэрлэг ан амьтаны бэлчээрийн бүсэд “Хөв цөөрөм” байгуулна
- 3.1.16 Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор утааны эсрэг амжилттай хэрэгжиж буй оновчтой шийдлийг нэвтрүүлнэ
- 3.1.17 Экологийн цагдаа, сайн дурын байгаль хамгаалагчдыг дэмжиж, байгаль орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ
- 3.1.18 Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын буруутай үйлдлийн улмаас байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж эвдэрч сүйтгэгдсэн газар нутгийг унаган төрхөнд нь оруулж, холбогдох хууль хяналтын байгууллагаар хариуцлага тооцуулж, иргэдэд мэдээлдэг болгоно



- 3.1.19 Заган ой, ховор ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх ажилд иргэд, төрийн бус байгууллагын оролцоог хангана
- 3.1.20 Төр, төрийн бус байгууллагын оролцоотой байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа, уул уурхайн компаний үйл ажиллагаанд “Стратегийн өмгөөлөл” явуулж, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээг авна
- 3.1.21 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд иргэд, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлүүдийн оролцоог хангана
- 3.1.22 Хамарын хийдийн хог хаягдлын цэгийг хашаажуулна

3.2 Хутагтын говь-Аялал жуулчлал

- 3.2.1 Хамарын хийдэд аялал жуулчлалын бүсийн цогцолбор байгуулж, говь нутагт амьдарч байсан палеонтологийн болон туурайтан, махчин, хөхтөн амьтдын олдвороор музей байгуулах ажлыг эхлүүлнэ
- 3.2.2 Дорноговь аймгийн “Есөн гайхамшиг” аялал жуулчлалын маршрутыг бий болгож, дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, дотоодын болон олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлнэ
- 3.2.3 Олон улсын Торгоны зам, ирээдүйд баригдах босоо тэнхлэгийн хурдны замын дагуу аялал жуулчлал хөгжүүлэх бодлого барина
- 3.2.4 Аялал жуулчлалын бүсэд стандартын шаардлагад нийцсэн худалдаа үйлчилгээ, зочид буудал, жуулчны бааз байгуулах хувийн хэвшлийн саналыг дэмжинэ.
- 3.2.5 Замын-Үүд, Ханги хилийн боомтуудыг түшиглэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 3.2.6 Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хооронд Ханбаянзүрх хайрханы орчимд төмөр замын өртөө байгуулж аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжинэ
- 3.2.7 Хамарын хийд орчмын тусгай хамгаалалттай газар нутгийн түүхийн дурсгалт газрын үндсэн тогтоцыг баримтлан аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлж, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулна
- 3.2.8 Хамарын хийдийн худалдаа үйлчилгээний бүсийг бий болгож, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ
- 3.2.9 Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааг бие даан үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлнэ



ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

4.1 Иргэдийн оролцоо-Нээлттэй төрийн алба

- 4.1.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг сайжруулж түргэн шуурхай, чирэгдэлгүй, иргэдийн оролцоотой хүргэх “Цахим төрийн алба” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.1.2 Төрийн байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхижуулах сургалтын нэгдсэн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг төлөвшүүлнэ.
- 4.1.3 “Хүний нөөцийн дэд хөтөлбөр” боловсруулж төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгоно.
- 4.1.4 Төрийн байгууллагуудын хуульд заасан нууцад хамаарахаас бусад үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгоно.
- 4.1.5 Иргэдийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгсөн захиргааны шийдвэр гаргах үйл явцад иргэдэд урьдчилан мэдэгдэж, оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.1.6 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, биелэлтийг цахимаар хянадаг болно.
- 4.1.7 Орон нутгийн онцлог, иргэдийн оролцоонд тулгуурлан Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг дээшлүүлнэ.
- 4.1.8 Иргэдийн эрх, эрх чөлөө, хариуцлага, хууль дээдлэх зарчмыг удирдлага болгон төрийн албаны хүртээмжийг нэмэгдүүлж, “Нэг цэгийн үйлчилгээ”, “Төрийн явуулын үйлчилгээ”-нд хамруулна.
- 4.1.9 Нутгийн удирдлагын тогтолцоонд хууль дээдлэх, шударга ёсыг эрхэмлэх, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллуулна.
- 4.1.10 Багуудын ажиллах нөхцлийг сайжруулж, Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг тогтмолжуулан, багийн ажлын албыг иргэдэд ойр ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 4.1.11 Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид төрийн албыг төлөвшүүлнэ.
- 4.1.12 Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, цахимаар явуулна.
- 4.1.13 Иргэдийн оролцоонд суурилсан болзошгүй гамшиг, эрсдлээс хамгаалах сан бий болгоно.
- 4.1.14 Иргэний нийгмийн байгууллага болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, тэдэнтэй хамтран ажиллана.



4.1.15 Тогтвор суурьшилтай ажиллах төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хямд өртөгтэй орон сууцаар хангана.

4.1.16 Иргэд төрийн үйлчилгээг нэг дороос авах ая тухтай боломжийг бүрдүүлж аймгийн болон зарим сумдын “Нутгийн удирдлагын ордон”-г шинэчлэх, өргөтгөх, засварлах ажлыг шийдвэрлэнэ

3.1.17 Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, нөхцлийг бүрдүүлэх, “Мэдээллийн нэгдсэн төв” ажиллуулна

3.1.18 Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, сургалтыг зохион байгуулна

3.1.19 Төрийн албаны ажил үүргийн даавардлыг арилгаж, анхан шатны нэгж багуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно

3.1.20 Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.2 Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин

4.2.1 Суурин газруудын гудамж талбайн тэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.2.2 Иргэдийн эрхийг хамгаалахад иргэн, төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж хамтран ажиллана

4.2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бодлогыг хэрэгжүүлж, иргэд олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэн дэмжиж ажиллана.

4.2.4 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.

4.2.5 Суурин газруудын болон уул уурхайн эдэлбэр газруудад байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, иргэдийн оролцоо, хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.6 Батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах төрийн бодлого, зорилтуудыг орон нутагт бүрэн хэрэгжүүлж ажиллана.

4.2.7 Батлан хамгаалах, Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын нийгмийн хамгааллын хүрээг өргөжүүлэх, офицер, ахлагч, чөлөөнд байгаа ахмадуудад чиглэсэн арга хэмжээг төрийн бодлоготой уялдуулан авч хэрэгжүүлнэ



4.2.8 Цахим аюулгүй байдлыг хангах төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжлийн байгууллагуудын хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхийг нэмэгдүүлнэ

4.2.9 Гамшигт үзэгдэл (ган зуд, газар хөдлөлт, хүн малын гоц халдварт өвчин, хүчтэй цасан болон шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгаанд тулгуурлан эрсдлээс урьдчилан сэргийлэх орон нутгийн бэлэн байдлыг хангаж ажиллана

4.3 Гадаад бодлого-Итгэлтэй түншлэл

4.3.1 Гадаад харилцаанд мөрдөгдөж байгаа гэрээ хэлэлцээрүүдийг үргэлжлүүлэн тодотгож, түншлэлийг нийгэм, соёл, хүмүүнлэгийн бүхий л хүрээнд өргөжүүлж ажиллана.

4.3.2 Гадаад харилцаанд үндэсний аюулгүй байдал, ард иргэдийн язгуур эрх ашгийн үүднээс зохистой тэнцвэрийг хадгалах бодлого барина.

4.3.3 Хамтын ажиллагаатай муж хотуудтай гэрээ хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд тэдний хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх бодлого барина.

4.3.4 Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг хангаж орон нутгийнхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ

4.3.5 Гадны хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа стратегийн өндөр ач холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийг орон нутгийн зүгээс бүх талаар дэмжиж ажиллана.



АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 1-6/626
танай _____-ны № _____-т

**АЙРАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Айраг сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Айраг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


Айраг сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Айраг сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Айраг сумын сонгуулийн хороонд

Хавсралт...⁹...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

Сумын МАН-ын хорооны 2020 оны 05-р сарын
28-ны өдрийн 21-досг тогтоолын хавсралт



АЙРАГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Айраг сумын Монгол Ардын Намаас орон нутгийн ИТХ-ыг сонгох 2020 оны сонгуульд оролцохдоо Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцох МАН-ын мөрийн хөтөлбөр, аймгийн ИТХ-д оролцох аймгийн МАН-ын мөрийн хөтөлбөр, тус сумын 2010-2021 оны ☐Хөгжлийн стратеги төлөвлөгөө☐-г удирдлага болгон боловсрууллаа.

Сум орон нутгийн нийгэм, эдийн засгийн өсөлтийг түргэтгэн, хүн амын боловсрол, мэдлэг чадварыг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлж иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэн аятай тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, Төрийн албаны шуурхай хариуцлагатай байдлыг хангаж ажиллахад уг хөтөлбөрийн ЭРХЭМ ЗОРИЛГО оршино.

НЭГ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

1.1. Дэд бүтэц, үйлдвэрлэлийг сайжруулах бодлого:

Бодлогын зорилт ☐ Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж бүтээн байгуулалт, дэд бүтцийг сайжруулан жижиг, дунд болон томоохон үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангана.

1.1.1 Сумын төвд үерийн ус зайлуулах нэгдсэн шугам сүлжээ, хоолой барьж байгуулах ажлын зураг төсвийг хийлгэж барьж байгуулах

1.1.2 Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орон сууц барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ

1.1.3 Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин төлөвлөлтөнд оруулах замаар шинэчилэх ажлыг хувийн хэвшлийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан шийдвэрлэнэ

1.1.4 Нутгийн удирдлагын ордонтой болох ажлыг шийдвэрлэнэ

1.1.5 Айраг сумын Хүндэтгэлийн хаалгатай болно



ХУУЛБАР ҮНЭН

1.1.6 Төрийн албан хаагчдын /дундын байр/ орон сууцнуудыг дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээнд холбох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтарч шийдвэрлэнэ

1.1.7 Орон нутагт хэрэгжиж буй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай томоохон үйлдвэрлэлийн төсөл хөтөлбөрийг бодлогоор дэмжиж ажиллан ажиллах хүчнийг орон нутгаас авах талаар гэрээ байгуулж ажлын байрыг нэмэгдүүлнэ

1.1.8 Сум хөгжүүлэх сангийн зээлийг жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж тогтвортой ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд хүртээмжтэй, оновчтой хувиарлах бодлогоор дэмжиж ажиллана.

1.1.9 Суманд усан спортын төв байгуулах талаар зураг төсөв гаргаж шийдвэрлэнэ

1.1.10 Сумын төвд цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг дээд байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх талаар бүхий л талын арга хэмжээ авч ажиллана

1.1.11 Бөөний худалдааны төв, хүнсний зах байгуулах иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагыг бодлогоор дэмжиж ажиллана

1.1.12 Сумын төвд хатуу хучилттай зам, явган болон дугуйн зам хийх ажлыг жил бүр шат дараатай хэрэгжүүлнэ

1.1.13 Сумын төвийн 1,7 км хатуу хучилттай замыг хамгаалж бордиур суулгах ажлыг шийдвэрлэнэ

1.1.14 Дулаан хангамжийн байгууллагуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч төв магистрал шугамыг шинэчлэх ажлыг эхлүүлнэ.

1.2 Хөдөө аж ахуйн бодлого

Бодлогын зорилт □ Малын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар хүртээмжийг сайжруулах, малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэх, газар тариаланг дэмжих төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх

1.2.1 Бэлчээрийн усан хангамжийг сайжруулан уст цэгийн тоог нэмэгдүүлнэ

1.2.2 Байгалийн болзошгүй эрсдэлийн үед мал сүргийг хамгаалах өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор тэжээлийн ургамал тариалах иргэн аж ахуйн нэгжид газар олгох, зээлэнд хамруулах зэрэг бүхий л талаар дэмжиж ажиллана.

1.2.3 □Төрөөс малчдын талаар баримтлах бодлого□, □Монгол мал хөтөлбөр□-ийг сумандаа үр дүнтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.4 Малын эрүүл мэнд удмын санг хамгаалах эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах талаар ~~хувийн мал эмнэлэгийн~~ үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.



ХУУЛБАР ҮНЭН

1.2.5 Мал нядалгааны цэгийн үйл ажиллагааг орчин үеийн стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах, үйл ажиллагааг нь тогтвортой байлгах талаар бодлогоор дэмжиж ажиллана.

1.2.6 Мал сүргийн бүтцийг сайжруулах, шилдэг омгийн малын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлнэ.

1.2.7 Малчдын дунд □Гар худаг□, □Хадлан тэжээл□ болзолт уралдаануудыг жил бүр зохион байгуулах

1.2.8 Бэлчээрийг хамгаалах үлийн цагаан оготно устгах талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж энэ ажлыг иргэд, малчдын бүлэг хоршоогоор гүйцэтгүүлж ажиллана

ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГО

2.1 Эрүүл мэндийн бодлого

Бодлогын зорилт □ Эрүүл мэндийн төвийн ажилтнуудын ажиллах таатай орчныг бүрдүүлэх оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж өвчлөлийг бууруулах

2.1.1 Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн чанартай хэрэгжүүлэх

2.1.2 Эмч эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг бодлогоор дэмжинэ

2.1.3 Эрүүл мэндийн төвийн барилгын цахилгааны шугам сүлжээг иж бүрэн засварлаж аюулгүй ажиллагааг хангана

2.1.4 Эмнэлэгийн байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж шат дараатай хангана

2.1.5 Хоол тэжээлийн дутагдалтай хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор □Гэр сувилал□-ыг жил бүр ажиллуулж эмчилгээ, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх талаар дэмжиж ажиллана

2.1.6 Эмийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, чанар стандартын шаардлага хангасан баталгаатай эм, эмнэлэгийн хэрэгслээр хангах ажилд хяналт тавьж мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана

2.1.7 Сумын Эрүүл мэндийн төвд шүд, осол гэмтлийн зэрэг нарийн мэргэжлийн эмчтэй болох асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж орон тоог батлуулах, энэ чиглэлээр нарийн мэргэжил эзэмших эмч нарын бодлогоор дэмжинэ

2.2 Боловсрол, салбарын бодлого



ХУУЛБАР ҮНЭН

Бодлогын зорилт □ Хүүхэд бүрт чанартай боловсрол олгох бүхий л нөхцөл боломжийг бүрдүүлж, оюунлаг, зөв хандлагатай, ахмад үе, үндэсний өв уламжлалаа дээдэлсэн иргэнийг бэлтгэх, багшлах боловсон хүчний хангамжийг бүрэн шийдвэрлэх

2.2.1 Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн 1-р байрны дотор талын иж бүрэн засварын ажлыг хийх

2.2.2 Сургалтын чанарыг ахиулах бүхий л нөөц боломжийг хэрэгжүүлж аймагтаа тэргүүлэх зорилт тавин хэрэгжүүлнэ

2.2.3 Сургуулийн биеийн тамирын гадна талбайн стандартын шаардлага хангасан дасгалын тоног төхөөрөмжийг бүрэн шийдвэрлэнэ

2.2.4 Насан туршийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж иргэдэд төрөл бүрийн сургалт мэдээллийг хүртээмжтэй чанартай хүргэх

2.2.5 Дотуур байрны хүүхдүүдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ

2.2.6 Багшлах боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг нь дэс дараатай шийдвэрлэнэ

2.2.7 Хүүхдийн цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сайжруулж багшлах боловсон хүчний мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд бодлогоор дэмжинэ

2.2.8 Хүүхдийн цэцэрлэгийн зөөлөн эдлэлийг бүрэн сольж шинэчилнэ

2.3 Соёл спортын бодлого

Бодлогын зорилт □ Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, соёл, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулж улс, тив дэлхийн хэмжээнд хүрэх урлаг спортын авьяастнуудыг олноор төрүүлэн гаргаж олон нийтэд гоо зүй ёс суртахууны хүмүүжилийг төлөвшүүлэх

2.3.1 Соёлын төвийн хуучин барилгын иж бүрэн засварыг хийлгэж ашиглалтыг сайжруулна

2.3.2 Соёл спортын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, арга хэмжээний чанар үр дүнд тодорхой ажиг гаргах, сумын аварга шалгаруулах төрөл бүрийн спортын уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулна

2.3.3 Түүх соёлын дурсгалт газрыг хамгаалалх, соёлын биет бус өвийг бүртгэж олон нийтийн хүртээл болгох ажлыг бодит үр дүнд хүргэнэ

2.3.4 Номын сангийн фондыг жил бүр нэмэгдүүлж иргэдийн дунд номтой нөхөрлөх аяныг зохион байгуулж ажиллана



- 2.3.4 Урлаг, спортын салбарт өндөр амжилт гаргаж сум орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөж яваа иргэд, хүүхэд залуучуудыг алдаршуулах ажлыг тухай бүрт нь зохион байгуулж нийтэд сурталчилах
- 2.3.5 Сумын хөл бөмбөгийн талбайг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулна
- 2.3.6 Угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг иргэдэд таниулах ажлыг зохион байгуулж ургийн бичиг хөтөлдөг өрхийн тоош нэмэгдүүлнэ
- 2.3.7 Иргэд, хүүхэд залуучуудын дунд урлаг спортын төрөл бүрийн дугуйлан секц ажиллуулж эрүүл чийрэг байж, ардын ёс заншил, ав уламжлалаа дээдлэх үзлийг төлөвшүүлэхэд онцгой анхаарч хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ
- 2.3.8 Тэмдэглэлт ой, баяр ёслолын үеэр иргэд, хүүхэд, залуучууд, ахмадууд, гэр бүлийн сайн сайханд чиглэсэн үр өгөөжтэй төрөл бүрийн урлаг спортын арга хэмжээнүүдийг уламжлал болгон зохион байгуулж хэвших

2.4 Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бодлого

Бодлогын зорилт Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж өрхийн орлогыг нэмэгдүүлж амьжиргааны түвшинг дээшлүүлэх

- 2.4.1 Халамжийн үйлчилгээг судалгаанд суурьлаж шаардлагатай иргэдийг оновчтой бүрэн хамруулна
- 2.4.2 Ахмад настнуудын халамж хамгааллын бодлогыг хэрэгжүүлж Аж ахуйн нэгж байгууллагуудад Ахмадын сан байгуулах хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана
- 2.4.3 Ахмадын өргөөний өргөтгөлийг хийлгэж тогтмол зардлыг бүрэн шийдвэрлэнэ
- 2.4.4 Ахмад настны зөвлөх үйлчилгээ, өдөр өнжүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ
- 2.4.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч, хөгжих, нийгмийн үйлчилгээг жигд хүртээх, дэмжих арга хэмжээнд түлхүү анхаарч ажиллана
- 2.4.6 Ажлын байрыг нэмэгдүүлэх талаар орон нутагт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана
- 2.4.7 Өрхийн орлогыг нэмэгдүүлэх хүсэлтэй амьжиргааны түвшин доогуур, өрх толгойлсон иргэдийг дэмжиж барьцаа хөрөнгө шаардахгүй бага хүүтэй зээл, хөтөлбөрт хамруулах



ХУУЛБАР ҮНЭН

- 2.4.8 Цөөн малтай малчин өрхийг “Малжуулах хөтөлбөр”-т хамруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 2.4.9 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн болон бусад 25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана
- 2.4.10 Нийгмийн даатгалын үйлчилгээний ач холбогдлыг иргэдэд сурталчилан таниулж эрүүл мэнд, сайн дурын даатгалд хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ

ГУРАВ: БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

3.1 Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого

Бодлогын зорилт □ Байгалийн баялаг, нөөцийг зохистой ашиглах, хүрээлэн буй орчноо хамгаалах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх

3.1.1 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг шат дараатай нэмэгдүүлнэ

3.1.2 Уул уурхайн олборлолтонд өртөж эвдэгдсэн газруудыг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэн хийнэ

3.1.3 Ашигт малтмал, баяжуулах боловсруулах үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, нийгмийн хариуцлагын гэрээг багийн иргэдийн оролцоотой хийдэг болгоно

3.1.4 Улсын тусгай хамгаалалттай □Цагаан дэлийн агуй□-н судалгааны ажлыг бүрэн хийлгэж, орчны техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийх, амны хэсгийг нь унаган төрхөнд нь оруулах ажлыг шат дараатай хийж тусгай хамгаалалттай газрыг бүрэн хашаажуулна

3.1.5 Сумын □Байгаль орчны менежментийн төлөвлөгөө□-ний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллана

3.1.6 Сумын хог хаягдлын нэгдсэн цэгийг булшилж шинээр тохиромжтой газарт байршуулж хог хаягдлын менежментийг сайжруулах

3.1.7 Хог хаягдлыг ангилан ялгаж хаях цэгийн тоог нэмэгдүүлэх, хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар иргэдэд сургалт сурталчилгааг хийж хэвшүүлэх

3.1.8 Хог зөөврийн автомашины тоог нэмэгдүүлж шинэчилнэ



ХУУЛБАР ҮНЭН

3.1.9 Дахин боловсруулах боломжтой хог хаягдалыг авах, дахин боловсруулах үйлдвэрлэл эрхлэх иргэн аж ахуйн нэгжид бага хүүтэй зээл олгох гэх мэт боломжит бүх бодлогор дэмжиж ажиллана

3.1.10 Суманд тохирсон ☐Тохижилтын алба☐ байгуулах үндэслэл судалгаа тооцоог гаргаж саналыг холбогдох газарт хүргүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн, хувийн хэвшлийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж ажиллана.

3.1.11 Гэр хорооллын гудамжны тохижилт өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор ☐Жишиг хашаа☐ хөтөлбөрийг боловсруулж иргэдийн оролцоотой шат дараатай хэрэгжүүлнэ

3.1.12 ☐Нэг иргэн нэг мод☐ аян өрнүүлж өрх бүрийг өрхийн гишүүний тоогоор мод тарих хөдөлгөөнийг жил бүр өрнүүлж ажиллана

3.2 Аялал жуулчлалын бодлого

Бодлогын зорилт ☐ Сумын нутаг дэвсгэрт байгаа Улсын тусгай болон орон нутгийн хамгаалалттай газар, аймаг сумын байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулан орон нутагтаа тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх

3.2.1 Сумын байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газруудыг хамруулан аялал жуулчлалын маршрут хийж, иргэд хүүхэд залуучуудыг аялалд хамруулж сум орон нутгаараа бахархах хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх ажлыг жил бүр зохион байгуулна

3.2.2 Улсын тусгай хамгаалалттай ☐Цагаан дэлийн агуй☐-н хамгаалалтыг сайжруулан хашаажуулан тэмдэг тэмдгэлээ хийх, амны хэсгийг нөхөн сэргээж байгалийн унаган төрхөнд нь оруулж аялал жуулчлалын маршрутанд оруулах

3.2.3 Цайны /торгоны/ замыг тэмдэгжүүлж аялал жуулчлалын маршрутанд оруулах, иргэдэд сурталчилан таниулах

3.2.4 Насан туршийн боловсролын сургалтанд хамрагдагсад болон хувиараа гар урлал, бэлэг дурсгалын зүйл хийдэг иргэдийг бодлогоор дэмжиж хийсэн бүтээлийг нутгийн брэнд болгох, борлуулах боломж нөхцөлийг бүрдүүлж ажиллана

ДӨРӨВ: ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

4.1 Төрийн үйлчилгээний бодлого

Бодлогын зорилт ☐ Төрийн үйлчилгээг иргэдийн оролцоонд тулгуурласан, ил тод, нээлттэй, хуулийг дээдэлсэн, мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай, төрийн албыг төлөвшүүлэх.



ХУУЛБАР ҮНЭН

4.1.1 Төрийн захиргааны албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх мэргэшүүлэх талаар онцгой анхаарч дотоодын болон бусад сургалт, хөтөлбөрт тогтмол хамруулах

4.1.2 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин төрийн албыг иргэдэд хөнгөн шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй хүргэж хэвшинэ

4.1.3 Төсвийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, ажлын цаг ашиглалтыг сайжруулан төрийн албаны стандартыг ханган ажиллаж харилцан туршлага мэдээлэл солилцон иргэдийг үнэн бодитой нэгдсэн мэдээ мэдээлэлээр хангах ажлыг шинэ шатанд гаргана

4.1.4 Татварын орлогыг төрөл бүрээр нь хуулийн хугацаанд бүрдүүлэх, орлого олох боломжит эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж Шилэн данс-ны үйл ажиллагааг нээлттэй болгох

4.1.5 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал авах ажиллагаанд иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх тэдэнд ойлгомжтой тайлбарлан таниулж оновчтой санал дэвшүүлэх ажлыг чанартай зохион байгуулж хэвших

4.1.6 Бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулж, хөрөгийг үр өгөөжтэй зарцуулах, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах төлөөр онцгой анхаарч ажиллана

4.2 Аюулгүй байдал, гамшгаас хамгаалах бодлого

Бодлогын зорилт Иргэдийн амгалан тайван байдлыг хангах, аятай тухтай амьдрах эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, салбар зөвлөлүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах

4.2.1 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар иргэдэд мэдээ мэдээлэл, хууль эрх зүйн сургалт сурталчилгааг мэдээллийн бүхий л хэрэгслээр болон биечилж хүргэх ажлыг дэвшилтэт шатанд хүргэнэ

4.2.2 Сумын Цагдаагийн тасаг, ГХУСАЗСЗ, Хүүхэд хамгаалалын хамтарсан баг, Хүүхдийн төлөө зөвлөл, Эцэг эхийн зөвлөлийн хоорондын уялдаа холбоог сайжруулан мэдээ мэдээллийг шуурхай солилцож хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт зэрэг гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллана

4.2.3 Суманд үйл ажиллагаа явуулдаг АА бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж нөлөөллийн арга хэмжээг хамтран хэрэгжүүлж хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ

4.2.4 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Малчдын бүлэг байгуулах ажлыг багийн Засаг дарга, БИИХ-ын Тэргүүлэгчидтэй хамтран зохион



ХУУЛБАР ҮНЭН

байгуулж бүлгүүдийн ажиллах чиглэл гаргаж урамшууллын системийг боловсруулан идэвхжүүлж ажиллана

4.2.5 Олон нийтийн байцаагчийн эрхийг баталгаажуулж сумын төвд гарч байгаа хог хаягдал, үхэр малаа сумын төв рүү оруулах, нохой муур олноор нь үржүүлсэн зэрэг бусдын эрүүл аюулгүй амьдрах орчинд саад учруулсан иргэдэд тавих хараа хяналтыг сайжруулан цэгцлэх, шаардлагатай бол хуулийн дагуу хариуцлага тооцох

4.2.6 Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор замын тэмдэг тэмдгэлгээ, самбар байршуулах, жолооч, зорчигчдод урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл хүргэх, ажлыг тогтмол зохион байгуулж осол гэмтлийн тоог бууруулах

4.2.7 Иргэд, ААН, байгууллагуудад галын аюулгүй байдал, аливаа гамшиг эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллага, ХАБЭА зөвлөл хамтран сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгуулах замаар гал түймэр, гамшиг ослын гаралтыг бууруулж ажиллана

4.2.8 Өсвөр үе, хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх талаар уралдаан тэмцээн, сургалт зохион байгуулах, уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх

4.2.9 Эх орноо батлах хамгаалах чиглэлээр иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цэргийн бэлтгэл үүрэгтнийг нөөцийг бүрдүүлж ажиллана

АЙРАГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



ХУУЛБАР ҮНЭН



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 16/627
танай _____-ны № _____-т

АЛТАНШИРЭЭ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанширээ сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Алтанширээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Алтанширээ сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Алтанширээ сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Алтанширээ сумын сонгуулийн хороонд

Хавсралт. 6...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

**АЛТАНШИРЭЭ СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНООС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үнэслэл

Тус сумын МАН-аас орон нутгийн ИТХ-ыг сонгох 2020 оны сонгуульд оролцохдоо Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцох МАН-ын мөрийн хөтөлбөр болон аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох аймгийн МАН-ын мөрийн хөтөлбөр, тус сумыг 2012-2022 он хүртэл хөгжүүлэх "Хөгжлийн хөтөлбөр"-ийг удирдлага болгоно.

Энэхүү мөрийн хөтөлбөрөөрөө сумын эдийн засаг, нийгмийн өнөөгийн бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж ирээдүйн 4 жилд орон нутгийг хөгжүүлэх шинэ боломж, гарцыг судлан, оновчтой, хэмжиж, хүрч болохуйц байдлаар төлөвлөхийг чухалчилсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Орон нутгийн эдийн засаг нийгмийн хөгжлийг түргэтгэн шинэ түвшинд гаргаж ажлын байрыг нэмэгдүүлж ард иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулж, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлсэн, төрийн албаны шуурхай хариуцлагатай байдлыг хангаж хүнрүүгээ, ирээдүйрүүгээ чиглэсэн цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Нийгмийн салбарын үйлчилгээг / боловсрол, эрүүл мэнд, соёл, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хамгаалал, даатгалын/ иргэдийн сэтгэл ханамжид нийцүүлж иргэдээ дээдэлсэн үйлчилгээг хүргэнэ

Зорилт 2. Хөрөнгө оруулалт бизнесийн таатай орчинг бий болгож, дэд бүтэцийг сайжруулж иргэдээ хөгжих, дэвших нөхцлийг бүрдүүлж өрх бүрийн орлого, амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах эдийн засагийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ

Зорилт 3. Өрх, иргэн бүр хоггүй цэвэр, ногоон орчныг эрхэмлэж, байгаль эхээ хайрлах өв уламжлалыг сэргээж, орон нутгийнхаа байгалийн үзэсгэлэнт болон түүх дурсгалын газрууддаа түшиглэн аялал жуулчлалын бодлого хэрэгжүүлнэ.

Зорилт 4. Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай, чадварлаг төрийн албыг төлөвшүүлнэ.



ХУУЛБАР ҮНЭН

НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

1.1 БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

1.1.1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг эрс сайжруулж, гадаад хэлний сургалтын орчинг бүрдүүлж шавь нарын нь сурлагын ахицаар сургууль багшын ажлыг дүгнэнэ

1.1.2. Багш нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, хөрвөх чадвартай багшийг бэлтгэхэд анхаарна

1.1.3. Бүтэн өнчин хүүхдэд боловсрол олгох мэргэжил эзэмшихэд нь бүх нөхцөл боломжоор хангана

1.1.4. Сургууль, цэцэрлэг хүүхэд бүрийг урлаг спортын аль нэг төрлөөр хичээллэх боломжийг бүрдүүлнэ

1.1.5. Сурагчдыг эх хэлээрээ илтгэх, сэтгэх, хэрэглээний бүрэн ур чадвартай болгож, Монгол хэлний сургалтыг сайжруулна

1.1.6. ЕБС-ийн сурагчдын ширээ сандалд шинэчлэл хийнэ

1.1.7. ЕБСургуульд их засвар хийнэ

1.1.8. Хүүхдийн цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ

1.1.9. Хүүхдийн цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг шинэчилнэ

1.1.10. Хүүхдийн цэцэрлэгийн дуу хөгжмийн танхимыг бүрэн тохижуулна.

1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1.2.1. Сумын Эрүүл мэндийн төвд стандартад заагдсан эмнэлгийн багаж хэрэгслээр хангаж, иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж ялангуяа яаралтай тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна

1.2.2. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хэрэгжилтийг улам эрчимжүүлж, В,С вирусн голомтыг бүрэн устгах ажлыг ойрын жилүүдэд дуусгана

1.2.3. Түргэн тусламжийн авто машиныг шинэчилнэ

1.2.4. Эрүүл мэндийн төвийн хуучин барилгад их засвар хийнэ

1.2.5. Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана

1.2.6. Эрүүл мэндийн төвийн ажилчдын орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3. СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

1.3.1. Соёлын биет болоод биет бус өвийг олж тогтоон, бүртгэл баримтлуулж хамгаалалтад авна

1.3.2. Соёлын төвд ажиллагсдын мэргэжил, боловсролыг дээшлүүлэхийн зэрэгцээ мэргэжлийн боловсон хүчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах бодлого барина.



ХУУЛБАР ҮНЭН

1.3.3 Монгол Ардын уламжлалт тоглоом наадгайг дэлгэрүүлнэ

1.3.4 Гоц авъяастныг дэмжинэ

1.3.5 Дуу, хөгжим, бүжгийн дугуйлан хичээллүүлнэ

1.3.6 Соёлын төвд гадна засвар хийнэ

1.3.7 Үзэгчдийн сандалын тоог нэмэгдүүлнэ

1.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.4.1 Төсөл хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байгаа ажилгүй, амжиргааны төвшин доогуур өрх, иргэдийг ажилтай орлоготой болгоход анхаарах, өрх толгойлсон эхчүүд, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.4.2 Залуу малчдыг малжуулах төсөлд шат дараатай хамруулна

1.4.3 Орон нутгийн залуучуудыг ажлын байраар хангахад анхаарч ажиллана

1.5 НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО

1.5.1 Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг ханган үйлчлүүлэгчдэд ёс зүйтэй, мэргэжлийн үйлчилгээг үзүүлэхэд анхаарах, тэдэнд тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авах, асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцлийг бүрдүүлнэ

1.5.2 Ахмадуудыг магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд амруулах бүх талын боломж нөхцлийг бүрдүүлнэ

1.5.3 “Ахмадын өргөө” барина

1.5.4 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймаг, суманд баригдах орон сууцанд ахмадууд, залуу гэр бүлийг эхний ээлжинд хамруулах бодлогыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ

1.5.5 Сайн дурын болон эрүүл мэндийн даатгалд даатгуулагчын тоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх ажлыг зохион байгуулна

1.5.6 Орон нутгаа хөгжүүлэх дэвшилтэт санал, санаачилга гарган төсөл хөтөлбөр боловсруулж ажиллана

1.5.7 “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулж ажиллана

1.5.8 Шинээр төгссөж байгаа боловсон хүчнийг сум орон нутагтаа ажиллах боломжийг бүрдүүлж ажиллана



ХУУЛБАР ҮНЭН

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛАХ БОДЛОГО

- 2.1.1. Сумыг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбох асуудалд идэвх санаачлагатай ажиллана
- 2.1.2. Худалдаа үйлчилгээний салбаруудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана
- 2.1.3. Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулалтанд оруулж иргэдийн ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана
- 2.1.4. Сум хөгжлийн сангийн хөрөнгийг жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох , тогтвортой ажлын байр нэмэгдүүлэхэд чиглүүлэн нийт иргэдэд хүртээмжтэй, зөв, оновчтой ашиглана
- 2.1.5. Орон нутагт үүрэн телефоны дахин дамжуулах станцыг нэмэгдүүлнэ
- 2.1.6. Сумын төвд спортын задгай талбай байгуулна
- 2.1.7. "Тэгш гудамж" төсөл хэрэгжүүлнэ
- 2.1.8. Иргэдийн хөгжлийн төв барина
- 2.1.9. Нийтийн орон сууц барина
- 2.1.10. "Эко бие засах газар" барина
- 2.1.11. Сум төвийн ундны усанд цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулж ухаалаг систем нэвтрүүлнэ

2.2. ХЕДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

- 2.2.1. "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого", "Монгол малчин", "Монгол мал" хөтөлбөр. "Атар-4" аяныг орон нутагт үр нөлөөтэй хэрэгжүүлнэ
- 2.2.2. Нутгийн шилмэл омог болон нутгийн сайжруулсан үүлдэрийн малын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх талаар ахиц өөрчлөлт гаргана
- 2.2.3. Сүргийн бүтэц, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан гажуудлыг засах шинжлэх ухааны үндэслэлтэй үе шаттай бодлого хэрэгжүүлнэ
- 2.2.4. Сумын уст цэгийн тоог нэмэгдүүлж, бэлчээрийн усан хангамжийг сайжруулна
- 2.2.5. Фермерийн аж ахуй, цагаан идээний үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ
- 2.2.6. Малчдын хоршоог төрийн бодлогын түвшинд бүх талаар дэмжиж ажиллана
- 2.2.7. Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг бодитой хийж бэлчээрийг зохистой ашиглахаар бэлчээрийн менежмент төсөл хэрэгжүүлнэ
- 2.2.8. Мах боловсруулах үйлдвэр барина
- 2.2.9. Хоршоог түшиглэн хөдөө аж ахуйн бирж ажиллуулж малчдад жуулчлах оновчтой хэлбэрийг олно



ХУУЛБАР ҮНЭН

2.2.10. "Хамар хөөвөрт" инженерийн хийцтэй услалтын систем байгуулж, малын тэжээлийн ургамал тариалах хувийн хэвшлийн саналыг дэмжинэ

ГУРАВ. ЗАСАГЛАЛ БА ГАДААД БОДЛОГО

- 3.1. Төрийн албанд сайн түшмэдийг дэмжиж шат ахиулан албан тушаал дэвшүүлэх "мерит" тогтолцоог мөрдөж ажиллана
- 3.2. Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг мөрдөж ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн төрийн албан хаагчдад хууль зүйн хариуцлагыг тооцно.
- 3.3. Төрийн захиргааны албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэх, дадлагажуулах, мэдлэг боловсролыг нь үе шаттайгаар дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллана
- 3.3. Ажлын цаг ашиглалтыг сайжруулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна
- 3.4. Сумын төсвийн байгуулагуудын ажлын уялдаа холбоог сайжруулна
- 3.5. Төрийн захиргааны албан тушаалтан ард иргэдийн өргөдөл гомдолыг хүлээн авч хуулийн хугацаанд нь шуурхай шийдвэрлэнэ
- 3.6. Сум оронд хийгдэж байгаа ажлын талаар иргэдийг мэдээллээр хангах мэдээлэл солилцох ажлыг сайжруулна
- 3.7. Цагдаагийн албан хаагчдыг унаажуулах, ард иргэдтэйгээ хамтарч ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулна
- 3.8. Гадаад харилцаагаа өргөжүүлэх идэвхтэй үйл ажиллагаа явуулж хөрш зэргэлдээ орнуудын адил түвшний байгууллагатай байнгын харилцаа тогтоож ажиллах
- 3.9. Гадаад орнуудын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судлах

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО
 - 4.1.1. Сумын тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, түүх дургалын газар, байгалийн үзэсгэлэнт газруудын хамгаалалтыг сайжруулах
 - 4.1.2. Байгаль орчны чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч эрчимжүүлнэ
 - 4.1.3. Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг олгох ардын уламжлалт арга ухаанд тулгуурласан сургалтуудыг үе шаттай зохион байгуулна



ХУУЛБАР ҮНЭН

4.1.4. 4.1.5. Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, бохирдон доройтож орхигдсон газар нутгийг нөхөн сэргээх ажлыг холбогдох аж ахуй нэгж, байгууллагуудаар хийлгэнэ

4.1.5. Мод тарих бүх нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ногоон төгөл байгуулах, цөлжилтийг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна

4.1.6. Байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд иргэд, нөхөрлөл, аж ахуй нэгж, төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжинэ

4.1.7. Иргэдэд үйлчилж байгаа бүх үйлчилгээний газарт болон гудамж талбайд хогийн савны тоог нэмэгдүүлж хоггүй сум болно

4.1.8. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөтэй болно

4.1.9. Айл өрх, иргэн бүр мод тарьж ургуулах уламжлалыг бий болгож тарьсан модыг бүртгэлжүүлнэ

4.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

4.2.1. Орон нутгийн хамгаалалттай Сэнжит хад орчмын газрыг тохижуулж, аялал жуулчлалыг татна

4.2.2. Хайлсан шандны амралтыг түшиглэн жуулчны бааз байгуулах хувийн хэвшлийг бодлогоор дэмжиж ажиллана





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 16/028
танай _____-ны № _____-т

**ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Даланжаргалан сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Даланжаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


Даланжаргалан сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Даланжаргалан сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Даланжаргалан сумын сонгуулийн хороонд

Хавсралт..(0...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

Сумын Монгол Ардын Намын хорооны
хурлын 2020 оны 4 сарын 6-ны өдрийн
... тоот тогтоолын хавсралт



ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ СОНГОХ 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Нэг: Нийтлэг үндэслэл:

Даланжаргалан сумын МАН-ын хороо сумын ИТХ-ын төлөөлөгчдийг сонгох 2020 оны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Тогтвортой хөгжил-2030 улсын дунд хугацааны бодлогын бичиг баримт, тус сумыг 2011-2025 он хүртэл хөгжүүлэх “Хөгжлийн мастер төлөвлөгөө”, Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцох МАН-ын мөрийн хөтөлбөр, аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох аймгийн МАН-ын хорооны мөрийн хөтөлбөр зэргийг удирдлага болгов.

Энэхүү мөрийн хөтөлбөрөөрөө сумын эдийн засаг, нийгмийн өнөөгийн бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж ирээдүйн 4 жилд сум орон нутгийг хөгжүүлэх шинэ боломж, гарцыг судлан, оновчтой, хүрч болохуйц, хэрэгжигдэхүйц байдлаар төлөвлөхийг чухалчилсан болно.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго:

Ажлын байрыг нэмэгдүүлж ард иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулж, сумандаа сайхан амьдрах боломжийг бүрдүүлж, байгальд ээлтэй, аялал жуулчлалыг хөгжүүлсэн, төрийн албаны шуурхай хариуцлагатай байдлыг хангаж хүндээ, ирээдүйдээ чиглэсэн цогц бодлогыг хэрэгжүүлсэнээр орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэн шинэ түвшинд гаргана

Гурав: Хөтөлбөрийн зорилт:

Зорилт:1. Нийгмийн салбарын үйлчилгээг \боловсрол, эрүүл мэнд, соёл, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хамгаалал, даатгалын\ иргэдийн сэтгэл ханамжид нийцүүлж, иргэдээ дээдэлсэн үйлчилгээг хүргэх

Зорилт:2. Хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бий болгож, дэд бүтцийг сайжруулж иргэдээ хөгжих, дэвжих нөхцлийг бүрдүүлж өрх бүрийн орлого, амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах эдийн засгийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт:3. Өрх, иргэн бүр хоггүй цэвэр, ногоон орчныг эрхэмлэж, байгаль эхээ хайрлах өв уламжлалыг сэргээж, орон нутгийнхаа байгалийн үзэсгэлэнт болон түүх дурсгалын газрууддаа түшиглэсэн аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт:4. Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж мэргэшсэн, тогтвортой, хариуцлага ёс зүйтэй, чадварлаг төрийн албыг төлөвшүүлнэ.



НЭГ: НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Боловсролын үйлчилгээ

- 1.1.1. Багшийн бүтээлч хандлагыг нэмэгдүүлж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд голлон анхаарч ажлын үр дүнгээрээ “аймагтаа тэргүүлэгч байх” зорилтыг бүх талаар дэмжиж ажиллана
- 1.1.2. Сургалтын чанарыг ахиулах бүхий л нөөц боломжийг судлан хэрэгжүүлнэ
- 1.1.3. ЕБС-ийн сурагчдын сурах, хөгжих таатай орчныг бүрдүүлж биеийн тамирын стандартын гадаа талбайтай болгоно
- 1.1.4. ЕБС-ийн сурагчдын техникийн сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд жил бүр зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулах
- 1.1.5. Байгалийн ухааны, гадаад хэлний хичээлийн болон бага ангийн /1/ кабинетийг байгуулж суралцах таатай орчинг бүрдүүлэх
- 1.1.6. Сумын хэмжээний сургуулийн насны хүүхдүүдийг өөрийн орон нутагтаа сургах бүхий л боломжит арга хэмжээг авч ажиллах
- 1.1.7. Хүүхдийн авьяасыг хөгжүүлж улс, аймаг бүсийн чанартай томоохон уралдаан тэмцээнд хамруулахад бодлогоор дэмжиж, бодит арга хэмжээг авч ажиллах
- 1.1.8. Багш нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөрвөх чадвартай багшийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх
- 1.1.9. Сургуулийн урлаг заалны их засварын ажлыг хийж гүйцэтгэх
- 1.1.10 ЕБС-ийн гадна талбайн тохижилт
- 1.1.11 Сурагчдын ширээ сандалыг шинэчлэх
- 1.1.12 Олон-Овоо бага сургууль болон сумын ЕБС-ийн их засварын ажлыг хийх
- 1.1.13. Багш нарын болон боловсролын байгууллагын ажилчин албан хаагчдын ажиллах нөхцлийг илүү сайжруулж компьютер, техник хэрэгслээр хангах
- 1.1.14 Цэцэрлэг, сургуулийг мэргэжлийн багшаар хангахад анхаарч бодлого хэрэгжүүлнэ
- 1.1.15. Орон нутгийн бүх иргэдэд НАСАН ТУРШИЙН боловсролын үнэ цэнэ болон иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тасралтгүй, төрөл бүрийн сургалтыг хүргэх байдлыг бүрдүүлж олон нийтийн ойлголт хандлагыг төлөвшүүлэн тэгш оролцоог хангаж ажиллана.



1.1.16. СӨБ-ын байгууллагыг биеийн тамирын гадна талбайд ашиглагдах сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах

1.1.17. Хүүхэд харах, асрах үйлчилгээг дэмжих замаар СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх.

1.1.18. Цомог багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг хувийн хэвшлийн байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэнэ.

1.1.19. Цомог багийн төвд шинээр ашиглалтад орох 2 Ус түгээх байранд ус түгээлтийн ухаалаг системийн төхөөрөмжийг суурьлуулна.

1.1.20. Олон-Овоо багийн УБТЗ-ын хувь нийлүүлсэн нийгэмлэгээс хувьчлагдаж хувь хүний эзэмшилд шилжсэн 11 орон сууцыг дулаан, цэвэр усны төвлөрсөн шугамд холбуулах ажлыг холбогдох байгууллагуудад уламжилж шат дараатай шийдвэрлүүлэх болон БИНХ-аар хэлэлцүүлж иргэдийн саналыг авч ОНХС-ийн санхүүжилтээр гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

1.1.21. Цомог багийн бохир усныг цэвэршүүлэх байгууламжийг барих

1.1.22. Суманд хоршоог түшиглэн ХАА-н бүтээгдэхүүний бирж ажиллуулж малчдад жуулчлах оновчтой хэлбэрийг бий болгоно.

1.1.23. ЖДҮ-ийг дэмжиж Даланжаргаланд үйлдвэрлэсэн нутгийн бренд бүтээгдэхүүнээр иргэд, ААНБ-ыг хангах бодлогыг баримтална.

1.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

1.2.1. Орчин үеийн шаардлагад нийцсэн эрүүл мэндийн төвийн барилга, Олон-Овоо багт өрхийн эмнэлэгийн барилгыг шинээр барих ажлыг үе шаттай шийдвэрлэнэ.


1.2.2 Тогтвор суурьшилтай ажиллах, өөрийн ажилдаа дур сонирхолтой эмч, сувьлагчдаас тодорхой шалгуураар сонгон шалгаруулж нарийн мэргэжлийн сургалтад хамруулан бэлтгэж тэдний сургалтын төлбөр болон нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэн тогтвортой ажиллуулах бодлого барьж ажиллана

1.2.3 Ардын уламжлалт эмчилгээний мэргэжлийн эмч сувилагчаар ханган, стандартын өрөө тасалгаатай болох

1.2.4 Олон-Овоо багт орон тооны сувьлагчтай болгох асуудлыг холбогдох газарт хүргүүлж бүрэн шийдвэрлэнэ

1.2.5 Эмнэлэгийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарч үе шаттай шийдвэрлэж ажиллана.

1.2.6. Нийтийн биеийн тамирыг дэмжиж энэ чиглэлээр орон нутагт хэрэгжүүлэх дунд, богино хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээс гадна иргэдийн санал



санаачилгад тулгуурласан клуб, секцийн үйл ажиллагааг дэмжиж орон тооны бус арга зүйчийн ажлын үр нөлөөг дээшлүүлнэ

1.2.7 Мооргыг цогцос хадгалах хөргөгчтэй болгоно

1.2.8 Яаралтай түргэн тусламжийн машиныг /2024 онд/ шинэчилнэ

1.3. Соёлын үйлчилгээ

1.3.1. Мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлого барьж одоо ажиллаж буй тогтвор суурьшилтай ажиллах ажилдаа дур сонирхол бүхий албан хаагчдыг бодлогоор дэмжин мэргэжилтэй болгож ажлын байрны шаардлага хангуулан ажиллуулна

1.3.2 Монгол үндэсний ардын хөгжмийн зэмсгийг нэмэгдүүлэх, хөгжим тоглох хүсэл сонирхолтой хүүхдүүдэд зааж сургах авъяасыг нь хөгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ

1.3.3 Сумын соёлын төвийг түшиглэн “Иргэдийн хөгжлийн төв” байгуулана

1.3.4 Угийн бичиг хөтлөлтөд анхаарч угийг бичигээ хөтөлдөг айл өрхийн тоог нэмэгдүүлнэ

1.3.5 Соёлын биет болон биет бус өв тээгчийн өв уламжлалыг хөгжүүлэх

1.3.6 Монгол ардын уламжлалт тоглоом наадгайг дэлгэрүүлэн хөгжүүлэх, өвлөн уламжлуулахад анхаарч ажиллана

1.3.7 Гоц авъястн, ардын авъяастан, уран бүтээлчийг бүх талаар дэмжиж, сурталжилж ажиллана

1.3.8 Цахим номын сантай болох, номын фондыг өргөжүүлэх

1.4. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого

1.4.1 Төсөл хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байгаа ажилгүй, амжиргааны түвшин доогуур өрх, иргэдийг ажилтай, орлоготой болгоход бодлого боловсруулж хэрэгжүүлнэ

1.4.2 Ажилгүйдэлийг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ

1.4.3 Орон нутагт уул уурхайн бүтээгдэхүүнийг олборлох боловсруулах баяжуулах чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй 25-аас дээш ажилтан албан хаагчидтай байгууллага аж ахуйн нэгжид ХБИ-ийг авч ажиллуулах, хэрэв ХБИ авч ажиллуулах боломжийн ажлын байргүй бол тухайн иргэнийг өөрийн байгууллагын аль нэг ажлын байранд томилж түүний ЭМ, НДШ-ийг төлж гарт олгох цалин хөлсийг /хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бууруулахгүйгээр/ олгодог байх зарчимаар ХБИ-нийг тогтмол орлоготой байлгах бодлогыг хэрэгжүүлж ажиллана



бууруулахгүйгээр/ олгодог байх зарчимаар ХБИ-нийг тогтмол орлоготой байлгах бодлогыг хэрэгжүүлж ажиллана

1.4.4 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Орлоготой залуу”, Оюутны ажлын байр хөтөлбөрт хамруулж ажиллана

1.4.5 Мал маллах сонирхолтой залуу гэр бүлийг малжуулах төсөлд хамруулана.

1.4.6 Ажилгүй иргэдийг тогтвортой орлоготой болгоход анхаарч ажилгүйдлийг үе шаттай бууруулах.

1.4.7 Өөрийн орон нутагт уул уурхайн бүтээгдэхүүнийг олборлох тээвэрлэх, баяжуулах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүдэд нутгийн иргэдийг ажиллуулахыг нийгмийн хариуцлагын гэрээнд тусгаж иргэдээ ажилтай орлоготой болоход анхаарч ажиллана

1.4.8 Мэргэжлийн чиг баримжаа олгох, өрхийн орлого нэмэгдүүлэх чиглэлийн сургалт, хөтөлбөрт иргэдийг хамруулж өрхийн тогтмол орлоготой болгоход нь бүх талаар дэмжлэг үзүүлж ажиллана

1.4.9 Гурав ба түүнээс дээш хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах, одонтой эхчүүдийн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Цалинтай ээж” хөтөлбөрт хамруулах

1.4.10 Өрх гэр бүлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх санал санаачлагыг дэмжих, “Бүтээлч гэр бүл” хөдөлгөөн өрнүүлэх зэргээр дундаж, түүнээс дээш орлоготой өрхийн тоог нэмэгдүүлэхийг зорьж ажиллана

1.5. Нийгмийн хамгааллын бодлого

1.5.1 Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг ханган үйлчлүүлэгчдэд ёс зүйтэй, мэргэжлийн үйлчилгээг үзүүлэхэд анхаарах, тэдэнд тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авах, асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцлийг бүрдүүлж ажиллана

1.5.2 Ахмадын зөвлөх үйлчилгээг дэмжиж идэвхжүүлнэ, ахмадын өргөөний тогтмол зардлыг бүрэн шийдвэрлэж ахмадуудыг нийгэмд идэвхтэй амьдрах нөхцөл боломжийг хангана.

1.5.3 Ахмадуудыг магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд амруулах бүх талын боломж нөхцлийг судлан хэрэгжүүлнэ.

1.5.4 ААНБ-ын дэргэд Ахмадын сан байгуулах хуулийн хэрэгжилтийг хангуулж ахмадуудын үйл ажиллагааг дэмжихэд нь идэвхжүүлж ажиллана

1.5.5 Гэр бүлд чиглэсэн нийгмийн халамжийн цогц үйлчилгээг хүргэхэд анхаарах



1.5.6 Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмж авдаг хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөрийн зах зээл рүү шилжүүлж зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж халамжийн дэмжлэг тусалцаанд бүрэн хамруулах

1.5.7 Нийгмийн халамжийн ажилтнуудын мэргэжил, боловсролыг нь дээшлүүлэх, нийгмийн ажилтнуудыг албан ерөөндөө бус нийгмийн эмзэг, дэмжлэг тусалцаа шаардлагатай өрх иргэнд хүрч, тосч, явж үйлчилдэг болгох.

1.5.8 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон эмзэг бүлгийн иргэдийг өөрийнх нь оролцоотой хөгжүүлэх, чадавхижуулах, дэмжих арга хэмжээнүүдийг авч ажиллахад анхаарах.

1.5.9 Жил бүр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж тогтоолгож байгаа иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангах, зуучлах ажлыг хэрэгжүүлэх

1.5.10 Сайн дурын болон эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах

1.5.11 Салбар болон мэргэжилтнүүдийн хамтын уялдаа холбоог сайжруулж, идэвхжүүлнэ

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Дэд бүтцийг сайжруулах бодлого

2.1.1 Олон-Овоо багийн төвийг бохир ус зайлуулах шугам, цэвэрлэх байгууламжтай болгох асуудлыг УБТЗ-ын хувь нийлүүлсэн нийгэмлэгт санал тавиж болон бусад боломжит санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж үе шаттай шийдвэрлэнэ

2.1.2 Цомог багийг цэвэрлэх байгууламжтай болгох асуудлыг шийдвэрлэнэ

2.1.3 Цомог багаас Олон-Овоо баг чиглэсэн цахилгаан дамжуулах агаарын шугам барьна

2.1.4 Сумын төвд баригдаж буй төвлөрсөн уурын зуух, нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугам тавих ажлыг чанартай гүйцэтгүүлж, хугацаанд нь дуусгахад хяналт тавьж ажиллана

2.1.5 Олон-Овоо багийн ажлын байранд засвар хийнэ

2.1.6 Олон-Овоо багт иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх өрхийн эмнэлэгийн барилгыг шинээр барьна

2.1.7 Сумын төвд инженерийн шугам сүлжээ бүхий 16 айлын орон сууцыг барина

2.1.8 Олон-Овоо багт ТАХ-ын амьдрах зориулалт бүхий 4 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулна

2.1.9 Төвлөрсөн багийн ундны усны худгыг цэвэршүүлэх төхөөрөмжтөй болгоно

2.1.10 Олон-Овоо багийн нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулж болзошгүй эрсдэл гэмт хэргээс урьдчлан сэргийлж ажиллана

2.1.11 Худалдаа, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

2.1.12 Бөөний худалдааны төв байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжиж ажиллана.



2.1.13. Биеийн тамир спортын задгай талбай байгуулах ажлыг дуусгуулж ашиглалтад оруулна

2.1.14 Өнгөт багийг багийн төвтөй болгох асуудлыг бүрэн шийдвэрлэнэ

2.1.15 Орон сууц, гэр байран дахь гэрэлтүүлгийг үе шаттай нэмэгдүүлнэ

2.1.16 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгж, иргэдэд үйлдвэрлэлийн усан хангамжийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.1.17 Сум хөгжлийн сангийн хөрөнгийг жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох, тогтвортой ажлын байр нэмэгдүүлэхэд чиглүүлэн нийт иргэдэд хүртээмжтэй, зөв, оновчтой ашиглана, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэж нэмж хугацаа хэтрэлт гаргахгүй ажиллана

2.1.18 Олон-Овоо багт 250 хүний суудалтай Соёлын төв барина

2.2 ХАА-н бодлого

2.2.1.Сүргийн бүтцийг сайжруулах, нутгийн шилдэг омгийн болон нутгийн сайжруулсан үүлдэрийн малын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх талаар ахиц өөрчлөлт гаргана,

2.2.2.Сумын уст цэгийн тоог нэмэгдүүлж, бэлчээрийн усан хангамжийг сайжруулна,

2.2.3.“Мах, сүүний анхдугаар “аян”-ныг орон нутагтаа зохион байгуулж фермер байгуулах санал санаачлагыг дэмжиж ажиллана

2.2.4.Мал нядалгааны цэг байгуулж, мах экспортлох замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх хувийн хэвшил, аж ахуйн нэгжид бүх талын дэмжлэг үзүүлнэ

2.2.5.Фермерийн аж ахуй, цагаан идээний үйлдвэрлэл эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана

2.2.6.“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” хөтөлбөрийг орон нутагтаа үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.2.7.Малчдын хоршоог төрийн бодлогын түвшинд бүх талаар дэмжиж хоршоог түшиглэн ХАА-н бирж ажиллуулж малчдад жуулчилна.

2.2.8 Мал сүргийг байгалийн болзошгүй аюулаас хамгаалах нөөц бүрдүүлэх, тэжээл үйлдвэрлэл эрхлэх хувийн хэвшил, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ, малчдад үйлчлэх иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

2.2.9.Малын гаралтай бүтээгдэхүүнд өртөг шингээх жижиг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүхий л талаар дэмжиж ажиллана

2.2.10 Сумын төвд өвс тэжээлийн агуулах барина



ГУРАВ: БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Байгаль орчны бодлого

- 3.1.1. Байгаль орчны чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд анхаарч эрчимжүүлнэ.
- 3.1.2. Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг олгох ардын уламжлалт арга ухаанд тулгуурласан сургалтуудыг үе шаттай зохион байгуулна
- 3.1.3. Сумын тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, түүх дурсгалын газар, байгалийн үзэсгэлэнт газруудын хамгаалалтыг сайжруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй гадаад дотоодын байгууллагуудын хамтын ажиллагааг тууштай дэмжин хамтран ажиллана
- 3.1.4. Уул уурхайн бүтээгдэхүүний хайгуул, олборлолтод өртөж, бохирдон доройтож, орхигдсон газар нутгийг нөхөн сэргээх ажлыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудаар хариуцлагатай чанартай хийлгэхэд онцгой анхаарч улмаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дүйцүүлэн хамгаалах замаар олон жилийн өмнө ухагдаж орхигдсон газрын нөхөн сэргээлтийг хийлгэнэ
- 3.1.5. Мод тарих бүх нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ногоон төгөл байгуулах, цөлжилтийг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 3.1.6. Цомог, Олон-Овоо багийн хогийн цэгийг цэгцэлж хашаажуулан байгальд халгүй төвлөрсөн хогийн цэгтэй болно
- 3.1.7. Байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж ажиллана
- 3.1.8. Нутаг дэвсгэрт байгаа болон хил залгаа аймаг сумын нутагт байрлах рашаан ус, булаг шандыг хамгаалах, сэргээх ажлыг тогтмол хийж жил бүрийн Дэлхийн усны өдрийг тохиолдуулан усийг хамгаалах, хайрлах, хэмнэх дадалд сургах ухуулга сурталчилгааг хийж хэвшүүлнэ
- 3.1.9. Айл өрх, иргэн бүр мод тарьж ургуулах уламжлалт сэтгэлгээг сэргээж Цомог багийн цэцэрлэгт хүрээлэнг бий болгохдоо иргэн, аж ахуйн нэгжүүд өөрийн тарьсан модоо арчлан ургуулж өөрөө амьдрах чадвартай болтол нь асран хамгаалах зөв дадал хэвшлийг бий болгоно
- 3.1.10. Иргэдэд үйлчилж байгаа бүх үйлчилгээний газарт болон гудамж талбайд хогийн савны тоог нэмэгдүүлж, Цэвэр сум аяныг жил бүр зохион байгуулж, хог хаягдлын зөв менежментийг хэрэгжүүлэх иргэн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана
- 3.1.11. Хилийн цэсийн маргаантай байгаа асуудлыг шийдвэрлүүлэхэд анхаарал хандуулна
- 3.1.12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй болгож хэрэгжүүлнэ
- 3.1.13. Хог хаягдлын тухай хууль журмыг иргэдэд сурталчлах, хог хаягдлыг зохих газарт хаядаг дадлыг иргэн бүрт хэвшүүлнэ

3.2. Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого

- 3.2.1. Сумын байгалийн үзэсгэлэнт болон түүх дурсгалын газруудыг холбосон аялал жуулчлалын маршрут бий болгож, аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн бодлого шийдвэрт тусгуулж хамтран ажиллана



3.2.2.Сумын онцлогт тохирсон аялал жуулчлалын маршруттай болж, аялал жуулчлалын үйл ажиллагаанд сумын оролцоог нэмэгдүүлнэ

3.2.3.Халзан уулын амралтыг түшиглэн жуулчны бааз байгуулах хувийн хэвшлийг бодлогоор дэмжиж ажиллах

ДӨРӨВ: ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

4.1 Иргэдийн оролцоонд тулгууралсан төрийн бодлого

4.1.1. Төрийн албаны тасралтгүй, тогтвортой байх бодлогыг сахин сайн түшмэдийг дэмжиж шат ахиулан албан тушаал дэвшүүлэх “мерит” тогтолцоог мөрдөж ажиллана

4.1.2.

Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг мөрдөж ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн төрийн албан хаагчдад хууль зүйн хариуцлагыг тооцож ажиллана

4.1.3.Төрийн захиргааны албан хаагчдыг тогтвор сууршилтай ажиллуулах мэргэшүүлэх дадлагажуулах, мэдлэг боловсролыг нь үе шаттайгаар дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллана

4.1.4.Төрийн албанд тухайн ажлын байранд тохирсон мэргэжлийн хүнийг томилж ажиллуулдаг зарчмыг хатуу баримтлана

4.1.5.Төрийн албыг хүнд сурталгүй, хөнгөн шуурхай, тосч хүргэх , ёс зүйтэй зарчимд бүрэн шилжүүлнэ

4.1.6.Төрийн бүх төрлийн үйлчилгээг иргэдийн үнэлгээгээр дүгнэдэг журамд шилжинэ.

4.1.7. Төсвийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, сайн туршлагаас суралцаж бүх байгууллага төрөөс баримталж буй стандарт нормыг хангаж ажилладаг болоход онцгой анхаарч тодорхой үр дүнд хүрнэ

4.1.8. Иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, мэдээлэл солилцох ажлыг сайжруулна

4.2 Аюулгүй байдал амгалан орчин

4.2.1 Цагдаагийн байгууллагатай болон иргэдийн мэдээлэл солилцох, хамтарч ажиллах шинэ гарцыг олж орон нутагт гарах гэмт хэргийн гаралтыг бууруулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулна

4.2.2 Гэмт хэрэг, архидан согтуурах явдлаас урьдчилан сэргийлэх ажилд бүх талын дэмжлэг үзүүлж нийгмийн бүх бүлэгтэй хамтран ажиллана

4.2.3 Малчдын бүлэг нөхөрлөлийг байгуулуулж, ажиллах журмыг СИТХ-аар батлуулан мөрдүүлж, хамтран ажиллаж мал хулгайлах гэмт хэргийг бууруулахад анхаарал хандуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана



4.2.4 Нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд үнэн зөв мэдээллийг худалдан авч мэдээлсэн иргэний нууцыг бүрэн хадгалж хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ

4.2.5 “Хүүхэд хамгаалалын баг”, “хамтарсан баг”, “Эцэг эхийн зөвлөл”, “хөршийн холбоо”, “ГХУСАЗСЗ”-ийн уялдаа холбоог сайжруулж харилцан мэдээлэлээ солилцож хамтран шийдэх замаар хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэл болон бусад эрсдэлээс хамгаалж аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана

4.2.6 Архинаас хамаарал бүхий иргэд, архидалт тогтмол явагддаг айл өрх, байгууллагыг судлан тогтоож тэднийг архинаас холдуулах, цаг заваа өөр зүйлд зориулдаг болгоход онцгой анхаар сургалт сурталчилгаа бусад холбогдох арга хэмжээг зохион байгуулах замаар ахуйн хүрээний архидалтыг багасгаж архитай холбоотой үйлдэгддэг гэмт хэргийн гаралтыг бууруулна,

4.2.7 Зам тээврийн осол гэмтэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авто замын орчимд болгоомжлуулсан тэмдэг тэмдэглэгээ байрлуулах шаардлагатай газруудад явган хүний гарц, хурд сааруулагч байрлуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах ажлыг тогтмол хийж хэрэгжүүлнэ

4.3 Итгэлтэй түншлэл гадаад бодлого

4.3.1 Гадаад харилцаанд мөрдөгдөж байгаа гэрээ, хэлэлцээрүүдийг үргэлжлүүлэн тодотгож хүчин төгөлдөр мөрдөнө.

4.3.2 Гадаад орнуудын улс төр, эдийн засгийн бодит сонирхлыг орон нутагт бий болгохдоо үндэсний аюулгүй байдал, ард иргэдийн язгуур эрх ашгийн үүднээс зохистой тэнцвэрийг хадгалах бодлого баримтална.

4.3.3 Орон нутгийнхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гадаад худалдааг үр ашигтай болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад анхаарна.

СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.09.06 № 1-6/629
танай _____-ны № _____-т

ДЭЛГЭРЭХ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дэлгэрэх сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Дэлгэрэх сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дэлгэрэх сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Дэлгэрэх сумын сонгуулийн хороонд

Хавсралт.../...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЭХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ “ДЭЛГЭРЭХ ХӨГЖИЛ-2024” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Дорноговь аймгийн Хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/, Дэлгэрэх сумын Хөгжлийн мастер төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд үндэслэн, сумын иргэд, намын гишүүдээс гаргасан саналыг нэгтгэн, ирэх 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх сонгуулийн мөрийн хөтөлбөрөө иргэд сонгогчид та бүхэндээ өргөн барьж байна.

“ДЭЛГЭРЭХ ХӨГЖИЛ-2024” мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа 2016-2020 онд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн биелэлтээ дүгнэж, өнгөрсөн дөрвөн жилд хийгдсэн болон ирэх онд хийгдэж дуусах бүтээн байгуулалт, нийгэм, эдийн засгийн салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд, түүний үр өгөөжийг өсгөн нэмэгдүүлэх, хөгжлийн тогтвортой байдлыг хангах зорилго тавьж, Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Аймаг, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан бодлогын баримт бичгүүд, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, 2017, 2018, 2019, 2020 оны улс, орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хуваарилалт зэрэг эрх зүйн баримт бичгээс гадна нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, ирээдүйн хөгжлийн чиг хандлага, газар нутгийн байрлал, иргэдийн амьдралын чанар, аж ахуй эрхлэгчдийн нөөц боломж, онцлох болон давуу талууд, мөн эрсдэлт хүчин зүйлсийг харгалзан үзсэн болно.

Сумын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр нь таван бүлэг, хорин зургаан хэсэгт эрэмбэлэн тусгасан, улс, орон нутгийн төсөв, засгийн газрын болон тусгай сан, орон нутгийн хөгжлийн сан, төрийн бус байгууллагын хандив, тусламж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

Дэлгэрэх сумын Монгол Ардын Намын хороо энэ удаагийн орон нутгийн сонгуульд “ХӨГЖЛИЙГ ХҮН БҮРТ” гэсэн уриатайгаар оролцож байна.



АГУУЛГА

НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

- 1.1. Үндэсний бахархал, эв нэгдлийг эрхэмлэсэн-Нүүдлийн соёл иргэншил
- 1.2. Эрүүл, аз жаргалтай, элэг бүтэн элбэг тэнүүн-Гэр бүл
- 1.3. Хүүхдэд ээлтэй сурах орчин-Мэргэжлийн баримжаа бүхий чанартай боловсрол
- 1.4. Хүний хөгжлийг тэтгэх-Идэвхтэй амьдралын хэв маяг, эрүүл мэнд, спорт
- 1.5. Соён гэгээрэлд тэмүүлсэн-Соёл урлаг, шинжлэх ухаан, мэдээлэл технологи
- 1.6. Орлогод нийцсэн-Орон сууцжуулах таатай орчин

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Хариуцлагатай, ил тод, хэмнэлттэй, үр ашигтай-Төсөв
- 2.2. Байгалийн баялгийн үр өгөөж-Хариуцлагатай уул уурхай
- 2.3. Хөгжилд хөтлөх-Дэд бүтэц
- 2.4. Чинээлэг-Монгол Малчин
- 2.5. Өрсөлдөх чадвартай нутгийн брэнд бүтээх-Хувийн хэвшил, ажлын байр
- 2.6. Газар тариалан, экологи- Эрүүл хүнсний хангамж

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1. Хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй-Ногоон хөгжил
- 3.2. Байгаль хамгаалалд-Бүх нийтийн оролцоо
- 3.3. Аялал жуулчлал-Соёлын гүүр

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН САЙН БОДЛОГО

- 4.1. Тогтвортой хариуцлагатай-Засаглал
- 4.2. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, иргэн төвтэй-Төрийн үйлчилгээ
- 4.3. Авилга хүнд сурталгүй, мэргэшсэн-Төрийн алба
- 4.4. Орон нутгийн өмчийн-Оновчтой менежмент
- 4.5. Амар тайван аюулгүй нийгэм

ТАВ. ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 5.1. Бүс нутгийн хөгжлийг дэмжих-Сайн хөршийн харилцаа
- 5.2. Иргэний оролцоонд түшиглэсэн-Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа
- 5.3. Их бүтээн байгуулалтыг дагаж өсөн нэмэгдэх-Зах зээлийн өргөн боломжууд



НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

1.1. Үндэсний бахархал, эв нэгдлийг эрхэмлэсэн-Нүүдлийн соёл иргэншил

- 1.1.1. Монгол улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлсэн эх оронч үзлийг сумын бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, насан туршийн боловсролын хөтөлбөрт суулгуулах, боловсролын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 1.1.2. “БИД ДЭЛГЭРЭХЧҮҮД” дэд хөтөлбөр боловсруулан Улаанбаатар хот дахь Дэлгэрэх сумын нутгийн зөвлөл, Сайншанд хот дахь Дэлгэрэх сумын Нутгийн зөвлөлийн хамт олон, гадаад улсад болон өөр орон нутагт оршин суугаа нутгийн уугуул иргэд, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл зэрэг салбарт амжилттай ажиллаж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдтэй сумын иргэд, аж ахуйн нэгжүүдээ холбож, хамтын ажиллагааг өргөн хүрээнд хөгжүүлнэ.
- 1.1.3. Нүүдлийн соёл иргэншлийн уламжлалт хэв шинжийг орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай хослуулан, Дэлгэрэх нутгийн брэнд болсон ардын богино болон уртын дуу, морин хуур, боржигон соёлын өвийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх “ХУУРЫН ЭГШИГТ ХУРДНЫ ӨЛГИЙ НУТАГ” хөтөлбөрийг соёл урлагийн байгууллагууд, иргэдийн оролцоонд суурилан хэрэгжүүлнэ.
- 1.1.4. Нүүдэлчин аж ахуйн онцлогт нийцсэн бэлчээрийн оновчтой менежментийг нэвтрүүлэн, нүүдэлчин ахуй соёл, хамтын амьдралын эв нэгдлийг эрхэмлэсэн “СААХАЛТ АЙЛ САЙН ХӨРШ” дэд хөтөлбөрийг иргэдийн оролцоонд суурилан хэрэгжүүлнэ.
- 1.1.5. Ахмад буурлуудаа хүндлэн дээдлэх, тэдний нийгмийн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, ахмад настны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр сумын Ахмадын холбоотой хамтран ажиллаж, ахмадуудад чиглэсэн соёл урлаг, эрүүл мэндийн үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй болгох, ахмадын холбооны байрыг төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээнд холбоно.
- 1.1.6. Ахмадын өргөөг ахмад настны сэргээн засах , эмчилгээ, сувилгааны тоног төхөөрөмтэй болгоно
- 1.1.7. Сумын ёслол хүндэтгэлийн өрөөг иж бүрэн тохижилттой болгож байнгын ажиллагаатай болгоно
- 1.1.8. Сумын наадмын талбайг “Монгол наадам” цогцолбор болгон тохижуулна.

1.2. Эрүүл, аз жаргалтай, элэг бүтэн элбэг тэнүүн-Гэр бүл

- 1.2.1. Ажилтай, орлоготой, бат бөх гэр бүлийн хөгжлийг дэмжин, хүүхэд-гэр бүл залуучууд, ахмадад чиглэсэн төрийн үйлчилгээг бүтээлч, хүртээмжтэй болгож, хүн амын өсөлтийг дэмжиж, хөдөлмөр эрхэлж буй эцэг, эхчүүдэд төрөөс олгодог дэмжлэг туслалцааг бүрэн олгож, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах талаар ажил олгогчидтой хамтран ажиллана.
- 1.2.2. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөрийн насанд хүрсэн гэр бүлийн гишүүдийг тогтвортой ажлын байраар хангах, ажил олгогчдыг бодлогоор дэмжин сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллана.
- 1.2.3. Өрхийн эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулж, гэр бүлийн гишүүдийн нас, хүйсийн онцлогт тохирсон үйлчилгээний шинэ бүтээгдэхүүн нийлүүлэх талаар



эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өрнүүлж, эрүүл шүд, элэг бүтэн монгол зэрэг хөтөлбөрүүдийн хүртээмжийг дээшлүүлнэ.

1.2.4. Гэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгддэг хэрэг зөрчил, хүчирхийллийг арилгах зорилгоор гэр бүлийн гишүүдэд чиглэсэн хүмүүжил ёс суртахууны боловсрол олгох “ЭВСЭГ НАЙРТАЙ ЭРҮҮЛ ГЭР БҮЛ” уриатай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.5. “ГЭРИЙН ХҮМҮҮЖИЛ-ДЭЛХИЙН БОЛОВСРОЛ” уриан дор “ДЭЛГЭРЭХ”-ээс дэлхийд тэмүүлсэн өв тэгш хүмүүжил, ёс суртахуунтай, шинэ Монголын иргэн бэлтгэх зорилгоор Сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллага, дунд сургууль, бусад төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж, 16 хүртэлх насны хүүхдүүдийг амьдралын зөв дадал, идэвхтэй хэв маягт хэвшүүлэх сургалт, хүмүүжлийн ажлыг тогтмол зохион байгуулна.

1.3. Хүүхдэд ээлтэй сурах орчин-Мэргэжлийн баримжаа бүхий чанартай боловсрол

1.3.1. Сумын цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалт хүмүүжлийн ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмж, эд материалын хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, цэцэрлэгийн дотор засал, агааржуулалт, ариутгал халдваргүйтгэлийн багаж хэрэгслийг сайжруулна.

1.3.2. Цэцэрлэгийн багш нарын ахуй хангамж, мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад үе шаттайгаар хамруулж, цэцэрлэгийн багш ажилчид, суралцагчдын албан хэрэгцээнд зориулан бага оврын автобусаар хангана.

1.3.3. Сумын дунд сургуулийн анги тохижилт, сургалтын орчинг сайжруулж, сурагчдын мэдээлэл технологийн танхим байгуулж, өндөр хурдны интернетэд холбон, компьютер, принтер, сканер, хувилагч тоног төхөөрөмжөөр хангана.

1.3.4. Сургуулийн багш ажилчдын ажиллах орчинг сайжруулж, ахуй хангамжийг нэмэгдүүлэн, мэргэжлийн зэрэг дэв дээшлүүлэх, давтан сурах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч, бага, дунд, ахлах ангийн сурагчдад зориулсан үндэсний өв соёл, уламжлалт хүмүүжил, эх түүхийн талаар тусгай хөтөлбөр боловсруулан тогтмол сургалт зохион байгуулна.

1.3.5. Сурагчдыг бие бялдрын өв тэгш хөгжил, оюуны өндөр чадамжтай, мэргэжлийн чиг баримжаа бүхий мэдлэг боловсролтой, шударга, ёс суртахуун, эрх зүйн ухамсартай эх оронч үзлээр хүмүүжүүлэх, нийтийн биеийн тамир, спортын төрлүүдийг хөгжүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Анги бүрт цэвэршүүлэгч шүүлтүүр бүхий цэвэр усны төхөөрөмж суурилуулна.

1.3.6. Сургууль, цэцэрлэгийг дулаан хангамж, цэвэр усны шугам, бохир зайлуулах магистрал шугамд холбох ажлыг гүйцэтгэж, цэцэрлэг сургуулийн хичээлийн байр, сургуулийн дотуур байрыг боловсон ариун цэврийн өрөөтэй болгож тохижуулна.

1.3.7. Сургууль цэцэрлэгийн хүүхдийн соёл урлаг, хүмүүжлийн ажилд зориулан нэгдсэн “Сурагч хөгжлийн төв”-ийг бий болгоно.

1.4. Хүний хөгжлийг тэтгэх-Идэвхтэй амьдралын хэв маяг, эрүүл мэнд, спорт

1.4.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвд хөл бөмбөг, сагс, гар бөмбөг, газрын теннис, гүйлтийн болон дугуйн зам, олон төрөлт дасгал хөдөлгөөнд зориулагдсан төхөөрөмж бүхий нийтийн биеийн тамирын талбайг байгуулж, ашиглалтад оруулан эрүүл идэвхтэй амьдрах, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.



- 1.4.2. Соёл спортын цогцолборт фитнесс танхим байгуулан жилийн дөрвөн улиралд тогтмол ажиллуулах, иргэдэд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.4.3. Спортын төрлүүдийг хөгжүүлэх зорилгоор биеийн тамир спортын байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж, мэргэжлийн боловсон хүчнээр ханган, сум, аймаг, бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцох баг тамирчдыг үе шаттайгаар бэлтгэх, сумандаа уралдаан тэмцээний эрх авч зохион байгуулна.
- 1.4.4. Морин спорт, морин уралдаан, сур, шагайн харваа, үндэсний болон сонгомол бөх, шатар, даам зэрэг спортын төрлүүдийг дэмжиж, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь бодитой дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.5. Сумын эрүүл мэндийн төвийн амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, эмчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, тохижуулах, өргөтгөх ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэн, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээ мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулна.
- 1.4.6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлж, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамж, шинэчлэл, засварыг тогтмол сайжруулж, байгууллага бүрийг ариутгал, халдваргүйтгэлийн нэгж, цэгтэй болгоно.
- 1.4.7. Эрүүл мэндийн төвийг төвлөрсөн дулаан, цэвэр усны хангамж, бохир зайлуулах шугамд холбоно.
- 1.4.8. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг оношлогооны хүртээмжийг нэмэгдүүлэн баг, өрхийн эрүүл мэндийн үйлчилгээг шинэ шатанд гаргана.
- 1.4.9. Сумын хэмжээнд зонхилон тохиолдох өвчлөлийн хэмжээг бууруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.

1.5. Соён гэгээрэлд тэмүүлсэн-Соёл урлаг

- 1.5.1. Ард иргэдээ соён гэгээрүүлэх уриалгыг идэвхийлэн дэмжиж, түүх соёлын биет болон биет бусыг өвийг хадгалан хамгаалах, түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтад авна.
- 1.5.2. Урлаг, утга зохиол, соёлын салбарт төрөн гарсан алдартнуудын дурсгалыг мөнхжүүлэх, залуу хойч үе залгамж халааг бэлтгэх, “ДЭЛГЭРЭХ”-чүүдийн оюун санааны баялаг болсон бүтээлүүдийг номын сан, орон нутгийн судлах музей, сургууль, цэцэрлэг, соёл спортын цогцолборт нийтэд хүртээмжтэйгээр байрлуулж, зохиогчийн эрхтэйгээр нийтэд түгээх үйлчилгээг тогтмол болгоно.
- 1.5.3. 500 хүний суудал бүхий “АЛТАН ГОВИЙН ДУУЛАЛ” хөгжимт театрын барилга барьж ашиглалтад оруулна.
- 1.5.4. Сумын хүүхэд залуучуудын оролцоонд түшиглэн морин хуур, үндэсний болон үлээвэр найрал хөгжим, утга зохиол, яруу найраг, дуу, бүжгийн “ЗАЛУУ ХҮЧ НЭГДЭЛ” уран бүтээлийн нэгдлийг байгуулж бодлогоор дэмжин ажиллана.
- 1.5.5. “ГЭГЭЭРЛИЙН ЦАГ” төсөл хэрэгжүүлэн түүх, соёл, урлаг, нийгэм, улс төр, эдийн засгийн сэдэвт шилдэг бүтээлүүд, шинэ мэдээ мэдээлэлтэй танилцах, сонсох, үзэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.5.6. Соёл урлагийн ажилтнуудыг чадавхижуулж, мэргэшүүлэх, давтан сургах чиглэлээр мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.

1.6. Орлогод нийцсэн-Орон сууцжуулах таатай нөхцөл



- 1.6.1. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэдийн захиалга, оролцоонд тулгуурлан, сумын хөгжлийн мастер төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн, сумын төв магистрал шугамд холбогдох боломжит газарт иргэдийн орлогод нийцсэн хямд өртөгтэй, чанартай орон сууцны хотхон бариулах “ШИНЭ ДЭЛГЭРЭХ” төслийг зохион байгуулж, захиалагч гүйцэтгэгчийн гүүр болж ажиллана.
- 1.6.2. Төв магистрал шугамд холбогдох боломжгүй алслагдсан айл өрхүүдийг “Хашаандаа сайхан амьдарья” уриан дор эко сууц барих, нарны эрчим хүчээр гэрэлтүүлэг, хэрэглээний усаа халаах, дулааны системээр хангах, цахилгаан эрчим хүчний зардлаа хэмнэх, эко бохирын байгууламж байгуулах боломж нөхцөлийг судлан, энэ төрлийн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдтэй холбож, амьдрах орчноо сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хариуцлагатай, ил тод, хэмнэлттэй, үр ашигтай-Төсөв

- 2.1.1. Төсвийн ил тод нээлттэй, хэмнэлттэй үр ашигтай байдлыг хангаж, хариуцлага дэг журмыг сахиулан ажиллана.
- 2.1.2. Улс, аймаг, сумын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, төрийн бусад сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгүүлсэн ажил, худалдан авсан бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг болон гүйцэтгэлийн төсөвт харьцуулсан хяналт тавьж, төсөв шамшигдах нөхцөл үүсгэхгүй байхыг шаардаж ажиллана.

2.2. Байгалийн баялгийн үр өгөөж-Хариуцлагатай уул уурхай

- 2.2.1. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах хуулийн шаардлагын биелэлт тогтмол үр дүнтэй хяналт тавьж, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, санал, зөвшөөрлийг авбал зохих асуудлуудыг нээлттэй хэлэлцүүлдэг, дүгнэдэг тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.2.2. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан, хүнсний хангамж, ажиллах хүчний нөөцөө тэргүүн ээлжид сумын иргэдээс авдаг, тогтвортой аюулгүй ажлын байраар хангадаг тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.2.3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс суманд оногдох хувийг дээшлүүлэх, хариуцлагатай ил тод, хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа байгаль орчин, хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл учруулахгүйгээр явуулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хариуцлагагүй уул уурхайг таслан зогсоох бодлого баримталж ажиллана.
- 2.2.4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд өгөх иргэдийн саналыг ажил хэрэгч бодитой, үр дүнтэй, хяналттай байдлаар зохион байгуулж, сумын нутаг дэвсгэрт хэрэгжих боловсруулах үйлдвэрлэлийн төслийг дэмжин ажиллана.
- 2.2.5. Уул уурхайн тээвэрлэлтийг батлагдсан маршрутаар, сайжруулсан замаар тээвэрлэхээс бусад тохиолдолд дэмжихгүй.



2.2.6. Ашигт малтмалыг хууль бусаар олборлох, байгаль орчныг бохирдуулах, эко системийг эвдэх явдлыг таслан зогсооно.

2.3. Хөгжилд хөтлөх-Дэд бүтэц

2.3.1. Сумын төвийг дулаан, цэвэр усаар хангах, бохир зайлуулах инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлж, төсөвт бүх байгууллагууд, төрийн албан хаагчийн орон сууцыг тэргүүн ээлжид холбох, иргэдийн захиалга, оролцоонд тулгуурлан айл өрхүүдийг үе шаттайгаар холбох ажлыг зохион байгуулна.

2.3.2. Сумын төвийн авто замын сүлжээг бий болгож, сайжруулсан шороон зам тавих, замын тэмдэг байрлуулах ажлыг зохион байгуулна.

2.3.3. Сумын төвийн гэрэлтүүлгийг сайжруулж, зарим цэгт шинээр гэрэлтүүлэг суурилуулна.

2.3.4. Сумын төвийн өндөр хүчдэл, цахилгааны найдвартай эх үүсвэрийг хангах зорилгоор Бор-Өндөрөөс татсан агаарын шугамтай сумын төвийг холбох (16 км ЦДАШ) асуудлыг шийдвэрлүүлнэ.

2.3.5. Цаг уур орчны шинжилгээний газрын барилгыг шинээр барьж, тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

2.4. Чинээлэг-Монгол Малчин

2.4.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 сарын 29-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Малчин” хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлэх бүхий л нөхцөл боломжийг эрэлхийлэн ажиллана.

2.4.2. Дэлгэрэх улаан ямааны ноолуураа бэлтгэх, борлуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, сурталчлах ажлыг дэмжинэ.

2.4.3. Дэлгэрэх нутгийн брэнд болсон Дэндэв тайж, Галсанбанди угшлын хурдан удмын адууны цөм сүрэг үүсгэж, малын удмын санд бүртгүүлэх, ажлыг зохион байгуулна.

2.4.4. Мал сүргийн ашиг шимийг өсгөх бодлого баримтлан цөм сүргийн нэгж байгуулах малчдын саналыг дэмжиж ажиллана.

2.4.5. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах, үнийн уналтаас сэргийлэх оновчтой бодлого баримталж ажиллана.

2.4.6. Бэлчээрийн усан хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. Сумын төвийн ундны усны эх үүсвэр, түгээх эцсийн цэгт цэвэршүүлэх шүүлтүүр тавина.

2.5. Өрсөлдөх чадвартай нутгийн брэнд бүтээх-Хувийн хэвшил, ажлын байр

2.5.1. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн арьс, шир элдэх, ноос угаах үйлдвэр, гар урлал, жижиг дунд үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжиж, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, зах зээлд холбож өгөх ажлыг тогтмол зохион байгуулна.

2.5.2. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх сонирхол бүхий иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж, иргэдийг хямд өртөгтэй бараа бүтээгдэхүүн үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулна.

2.5.3. Сүү, сүүн бүтээгдэхүүн, талх, нарийн боовны үйлдвэр, худалдааг дэмжинэ.

2.6. Газар тариалан, экологийн эрүүл-Хүнсний хангамж



- 2.6.1. Төмс, хүнсний ногоо, жимс, хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжиж, хэрэгцээт газар зохион байгуулалт, усжуулалтын системийг байгуулахад мэргэжлийн байгууллагын зөвлөмж, мэргэжилтнээр туслах ажлыг зохион байгуулна.
- 2.6.2. Бэлчээрийн даацн хэтрэх асуудал хэт өндөр байгаагаас шалтгаалан цөлжилт үүсэж буй явдалтай холбогдуулан өвөлжөө, хаваржаа, уст цэгийг дагасан тэжээлийн ургамал тариалалт хийх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулна.
- 2.6.3. Аливаа гамшигт үзэгдэл, гоц халдварт өвчин, цар тахал зэрэг эрсдэлд хүчин зүйл, мөн хүн амыг эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах, онцгой нөхцөл байдалд бэлэн байдлыг хангах зорилгоор сумын төвд мах хөргүүртэй агуулах, ногооны зоорь барьж хүнсний нөөцийг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.
- 2.6.4. Сумын иргэдийг жилийн 4 улирлын турш шинэхэн хүнсээр хангах хүнсний ногоо, махны зориулалтын зоорьтой болох.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй-Ногоон хөгжил

- 3.1.1. Сумын нутаг дэвсгэрт явуулж буй үйлдвэр үйлчилгээ, төсөл хөтөлбөрүүдийг хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй байдлаар зохион байгуулж явуулах бодлого баримтална.
- 3.1.2. Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн болон иргэдийн ахуйн хэрэглээнээс гарч буй химийн хорт, аюултай хог хаягдлыг анхдагч цэг дээр ялгаж, цуглуулах, тээвэрлэх, устгах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог хангана.
- 3.1.3. Дахин боловсруулах боломжтой хаягдал, хоёрдогч түүхий эдийг цуглуулах, худалдан борлуулах, урамшууллын оновчтой системийг нэвтрүүлнэ.
- 3.1.4. “НЭГ МОД-НЭГ АМЬ” хөтөлбөр боловсруулж, сумын төвийн айл бүр хашаандаа мод тарих, сумын төвийн байгууллага бүр гаднаа мод тарих, авто зам, явган хүний зам дагуу мод тарих хөдөлгөөнийг өрнүүлэн ногоон хөгжлөөр давамгайлсан шинэ сууринг цогцлооно.

3.2. Байгаль хамгаалалд-Бүх нийтийн оролцоо

- 3.2.1. Эх нутгийнхаа онгон дагшин байгаль, экосистемийг хамгаалахад иргэн бүрийн оролцоог хангаж, “Эрүүл аюулгүй-Амьдрах орчин” хөтөлбөр хэрэгжүүлж, сумын төвийн хог хаягдлын нэгдсэн цэгт дахин төлөвлөлт хийх, сумын төвийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, өвөлжөө, хаваржаа, зун, намрын нутагласан газар орны хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх, устгах ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулна.
- 3.2.2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй иргэн, байгууллагыг урамшуулах, үйл ажиллагааг нь бодлогоор дэмжиж, нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 3.2.3. Булаг, шанд, ундны усны эхийг хамгаалалтад авч, тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 3.2.4. Сумын нутаг дэвсгэрт усны хайгуулын нэгдсэн судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлнэ.



3.3. Аялал жуулчлал-Соёлын гүүр

- 3.3.1. Дорноговь аймгийн Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд тусгагдсан тавдугаар бүс зам болох Их бага Эрээний нурууны байгалийн аяллын бүсэд багтах Цонжийн чулуу, Маналын найман суравга, Жингирт уулын агуй, Далайн хөндийн хөшөө чулуу гэсэн газруудыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтлан аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэд, байгууллагыг дэмжиж ажиллана.
- 3.3.2. Жил бүр уламжлал болон тогтсон хамрын хийд, Шамбалын орон, ханбаянзүрх хайрхан чиглэлийн шашин соёлын аялал жуулчлалыг дэмжиж ажиллана.
- 3.3.3. “Тайжийн Хурд” аймгийн бүсийн морин уралдааныг түшиглэн бизнес, спортын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН САЙН БОДЛОГО

4.1. Тогтвортой хариуцлагатай-Засаглал

- 4.1.1. Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах сумын засаглалын сайн бодлогыг төлөвшүүлж, тогтвортой, хариуцлагатай засаглалын бодлого баримтлан ажиллана.
- 4.1.2. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд үндэсний язгуур эрх ашиг, эв нэгдлийг эрхэмлэн, сумын нийгэм эдийн засгийн асуудлыг бие даан шийдвэрлэх үйл ажиллагааг чадавхижуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.2. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, иргэн төвтэй-Төрийн үйлчилгээ

- 4.2.1. Нэг цонхны үйлчилгээг төгөлдөржүүлж, иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- 4.2.2. Сумын Засаг даргын тамгын газрын барилгын их засвар, өргөтгөлийг хийж, иргэд үйлчлэх танхимыг шинээр байгуулна.
- 4.2.3. Сумын Засаг даргын тамгын газрын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг эрчимжүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг саадгүй шуурхай үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.2.4. Цагаан хад багийн төвийг эрчим хүчинд холбох, Аманшанд, Бумбат багийн төвүүдийг зөөврийн цахилгаан эх үүсвэртэй болгох, тохижуулах ажлыг хийнэ.

4.3. Авилга хүнд сурталгүй, мэргэшсэн-Төрийн алба

- 4.3.1. Төрийн албан хаагчийн мэргэшсэн байдал, хариуцлага, ёс зүйг чанд сахиулж, иргэнд алагчлалгүй түргэн шуурхай үйлчлэх, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид байх орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- 4.3.2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид, тусгай албан хаагчид улс төрөөс ангид байх, нэгдмэл удирдлага зохион байгуулалтыг хангаж ажиллана.

4.4. Орон нутгийн өмчийн-Оновчтой менежмент

- 4.4.1. Улс, аймаг, сумын төсөв, хөрөнгө оруулалт, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хандив тусламжаар бүтээн байгуулж, худалдан авч, шилжүүлэн өгсөн орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар шинэ бодлого



баримтлан ажиллаж, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг дарга, бусад байгууллагууд орон нутгийн өмчийн өмчлөл, ашиглалт, хамгаалалт, хадгалалтад нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэн, эд хариуцагч бүртэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулан ажиллах тогтолцоог бүрдүүлнэ.

- 4.4.2. Засаг даргын тамгын газрын харьяа орон нутгийн өмчит хот тохижилт үйлчилгээний бүтцийг байгуулан, сумын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, нийтийн зориулалттай зам, талбай, байгууламжийн ашиглалт хамгаалалт, хог хаягдлын асуудлыг хариуцуулна.
- 4.4.3. Төрийн өмчит, төсөвт байгууллагын нэгдсэн авто зогсоол, аж ахуйн хашааг байгуулан төвлөрсөн удирдлага, хяналтаар хангаж ажиллана.

4.5. Амар тайван аюулгүй нийгэм

- 4.5.1. Иргэдийн амар тайван аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, камерын хяналтын цэгүүдийг оновчтой байрлалд байршуулна.
- 4.5.2. Суурин газарт замын хөдөлгөөний дүрмийг мөрдөхөд хялбар ойлгомжтой болгох үүднээс төв болон туслах зам, явган хүний гарц, зогсоол зэргийг ялгасан замын тэмдгүүдийг байршуулж, замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж өгнө.
- 4.5.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлыг шинэ шатанд гаргаж, хяналт шинжилгээ, үнэлгээг нийтэд ил тод, нээлттэй болгож, иргэд аж ахуйн нэгж, хуулийн байгууллагатай хамтран ажиллана.
- 4.5.4. Суманд гал унтраах машин бүхий, гамшгаас хамгаалах байнгын ажиллагаатай нэгжийг байгуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ТАВ. ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

5.1. Бүс нутгийн хөгжлийг дэмжих-Сайн хөршийн харилцаа

- 5.1.1. Өөрийн аймгийн хил залгаа Өргөн, Алтанширээ, Иххэт, Хэнтий аймгийн Галшар, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Баяндэлгэр сумдтай хамтын ажиллагааны санамж бичиг зурж, бэлчээр ашиглалт, отор нүүдлийн асуудлыг харилцан ойлголцож иргэддээ ээлтэй байдлаар шийдвэрлэх, гэмт хэрэг зөрчил, мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл солилцох оновчтой зохион байгуулалтыг хийж өгнө.
- 5.1.2. Ажил үйлсээрээ манлайлж буй аймаг, сум, дүүрэг, хот тосгодтой хамтын ажиллагааг өргөжүүлж шилдэг тэргүүний туршлагыг нэвтрүүлэн харилцан суралцаж, хамтдаа хөгжих орчинг бүрдүүлнэ.
- 5.1.3. Харилцан үр ашигтай нээлттэй гадаад харилцааг эрхэмлэн гадаад улсын ижил төрлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өрнүүлж, нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

5.2. Иргэний оролцоонд түшиглэсэн-Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа

- 5.2.1. Сумын хэмжээнд хэрэгжүүлж буй бүтээн байгуулалт, аливаа төсөл хөтөлбөрүүдийг өөрийн сумын иргэд, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх, иргэд, аж ахуйн нэгжүүдэд



чадавхижуулах бодлого баримтлан ажиллаж, ажлын байраа хадгалах, иргэдээ ажилтай орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

- 5.2.2. Сумын төвийн айлууд төвлөрсөн дулаан хангамж, цэвэр бохир усны шугамд холбогдох нөхцөлийг бүрдүүлж, сумын төвд хэрэглээний усны 2 худгаар дамжуулан ус түгээх үйлчилгээг эрхлэх аж ахуйн нэгжийг түшиглэн ажлын байрыг нэмэгдүүлэх, сумын иргэдээ ажлын байраар хангах талаар хамтран ажиллана.

5.3. Их бүтээн байгуулалтыг дагаж өсөн нэмэгдэх-Зах зээлийн өргөн боломжууд

- 5.3.1. Өнгөрсөн дөрвөн жилд Дорноговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн их бүтээн байгуулалт, ирэх дөрвөн жилд Засгийн газраас болон орон нутгаас хэрэгжүүлэх, төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугам, боловсруулах үйлдвэрүүд, мөн суманд баригдаж буй Уурын зуухны бүтээн байгуулалтыг дагасан хүн амын төвлөрөл, ажлын байрны эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсон хүчин, мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, сургах, ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.3.2. Их бүтээн байгуулалт дагасан зах зээлийн эрэлтэд нийцэх бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг судлан сумын хэмжээнд өөрөө үйлдвэрлэх, ханган нийлүүлэх боломжит бүтээгдэхүүнийг худалдан борлуулах зах зээлийн орчинг бүрдүүлж, иргэдийн орлого нэмэгдүүлэх үе шаттай арга хэмжээг авна.

Ажлын байрны
төвлөрөл
Дорноговь
аймгийн
Хүрээ

4417144398
ЕЮА0056 0228707



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

1020.04.06 № 1-6/640
танай _____-ны № _____-т

ИХХЭТ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иххэт сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Иххэт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иххэт сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иххэт сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Иххэт сумын сонгуулийн хороонд

Хавсралт...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

Батлав. Иххэт сумын Монгол Ардын Намын хорооны
2020 оны 05-р сарын 28-ны өдрийн 09/22 тогтоолын хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНООС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

УРИА: НУТГАА ХӨГЖҮҮЛЭХЭД

ИРГЭН БҮХЭН ЗҮТГЭЕ.

Сумын МАН-ын хорооноос сумаа хөгжүүлж орон нутгийнхаа иргэдийн сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлж ирээдүйгээ харсан тогтвортой хөгжлийн бодлогыг Сумын Нийгэм Эдийн Засгийн тогтвортой хөгжлийг гадаад дотоодын хөрөнгө оруулалт, олон улсын төсөл, хөтөлбөр, хувийн хэвшлийн болон бусад эх үүсвэрүүдийг зөв бодлогоор дэмжин хангаж, их бүтээн байгуулалт өрнүүлэн төрөлх сумаа 2021-2024 он хүртэл хөгжүүлэх цогц арга хэмжээг энэхүү мөрийн хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

Нэг: Нийгмийн бодлого

**/ТОГТВОРТОЙ ОРЛОГОТОЙ, АЖЛЫН БАЙРТАЙ, ОЮУНЛАГ, ЭРҮҮЛ ИРГЭН
ТАНЫ ТӨЛӨӨ ХАМТДАА/**

- 1.1 “Ажлын байр” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.2 Ажилгүйдлийг бууруулах чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд анхаарч эрчимжүүлнэ.
- 1.3 Ажилгүйдлийг үе шаттай бууруулж, хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ.
- 1.4 Мэргэжилтэй боловсон хүчнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд дэмжиж ажиллана.
- 1.5 Нийтийн халуун усны газар нээж тогтмол ажиллуулна.
- 1.6 Унданы усны ус түгээх байруудад ус цэвэршүүлэх төхөөрөмжтэй болгоно.
- 1.7 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана.
- 1.8 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, уул уурхайг төрийн бодлогоор дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.9 Арьс түүхий эд боловсруулах цех ажиллуулна.
- 1.10 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- 1.11 Суманд орон сууцийг нэмэгдүүлнэ




Хоёр.Бүтээн байгуулалт

- 2.1 Сумын багачууд цэцэрлэгийн барилгын их засварыг хийнэ.
- 2.2 Сумын Соёлын төвийн урсгалт засварыг хийлгэнэ.
- 2.3 Засаг Даргын Тамгын Газрын урсгалт засварыг хийлгэнэ.
- 2.4 Сумын төвийн 8-р худгийн унданы усны шугамыг солиулна.
- 2.5 Өвсний фондтой болгоно.
- 2.6 Бүтэн камержуулалтын тоог нэмэгдүүлнэ.
- 2.7 Гэр байрыг жишиг гудамжтай болгоно.
- 2.8 Гэр байрны муу ус болон нойлийг жигдэрүүлэнэ.
- 2.9 Хогийн нэгдсэн цэгийг автоволдох ажил хийнэ.
- 2.10 Өрх бүр мод тарьж эко орчинтой болгоно.
- 2.11 СӨХ-ны ажлыг дэмжиж ажиллана.
- 2.12 Гэр хорооллуудыг гэрэлтүүлэгтэй болгоно.
- 2.13 Гэр байрыг нэршилээр нь хаягжуулна.

Гурав. Байгальд ээлтэй бодлого

ӨВӨГ ДЭЭДСЭЭС ӨВЛҮҮЛСЭН УНАГАН БАЙГАЛАА ХАЙРЛАЯ

- 3.1 Улсын болон аймаг сумын тусгай хамгаалттай газар нутгийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, ховор ан амьтан, ургамал, түүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулна.
- 3.2 Байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд иргэд, нөхөрлөл, аж ахуй нэгж төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжинэ.
- 3.3 Уул уурхай хайгуул олборлолтод өртөж бохирдон доройтож орхигдсон газар нутгийг нөхөн сэргээх ажлыг холбогдох аж ахуй нэгж байгууллагуудаар хийлгэнэ.
- 3.4 Уул уурхай бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллана.
- 3.5 Зүлэгт багийн булаг шандны усыг хашаажуулж хамгаалалтанд авна.
- 3.6 Мал угаалгын ажлыг тогтмолжуулна.



3.7 Үерийн даланг сэргээж шинээр хийнэ.

3.8 Гэр хороолол дэнж хоёрын хооронд явган хүний гарц хийнэ.

3.9 Өрхөөс гарч байгаа хаягдал хогийг ялгаж ангилах, дахин боловсруулхыг дэмжинэ.

Ялгаж хаях хогийн савыг өрх бүрт хэрэглэж хэвшүүлнэ.

Дөрөв. Төрийн албаны бодлого

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛЖ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХЫН ТӨЛӨӨ ХАМТДАА

4.1 Төрийн албыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж ажиллана.

4.2 Шинээр ажиллахаар ирж байгаа боловсон хүчнүүдийг дэмжиж ажиллана.

Иххэт сумын Монгол Ардын Намын хорооноос дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр нь нийгмийн ардчилалын үзэл баритлалын хүрээнд нарийн тооцоо судалгаанд тулгуурласан ба иргэн төвтэй Иххэт сумыг хөгжүүлэхэд чиглэгдэж, ард иргэдийн амьдралд бодит ахиц гаргах баримт бичиг юм.

ИХХЭТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 11-6/631
танай _____-ны № _____-т

**МАНДАХ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мандах сумын Хурлын сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Мандах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Мандах сумын "Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мандах сумын "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг: Мандах сумын сонгуулийн хороонд

Хавсралт...3...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА



**ОРОН НУТГИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МАНДАХ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

1. Өрхийн амьжиргааны төвшинг тодорхойлж нэн ядуу, ядуу өрхөд чиглэсэн нийгмийн халамжийн цогц арга хэмжээг төр, засгийн бодлоготой уялдуулан сумын хэмжээнд авч хэрэгжүүлнэ Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй, үйлдвэр, төмөр зам, уул уурхайд тулгуурлан, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс явуулж байгаа уул уурхайн ажилд нутгийн иргэдийг хамруулж, тэднийг ажлын түр болон байнгын ажлын байраар хангах бодлого баримтална
3. Орон нутаг судлах музейг тохижуулана.түүхийн дурсагалт газаруудыг бүртгэлжүүлэн хамгаалалатыг сайжруулах.
4. Байнгын болон түр ажлын байранд шаардагдах сургалтуудыг холбогдох байгууллагаар дамжуулан үе шаттай зохион байгуулж, амьдралын баталгаажих төвшнөөс доогуур орлоготой иргэдийг өргөнөөр хамруулна.
5. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН байгууллагуудтай хамтран мэргэжилтэн бэлтгэх тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.
6. Мэргэжилтэн ахмадуудаас бүрдсэн зөвлөгөө өгөх ахмадын зөвлөлийг байгуулна.
7. Гэр цэцэрлэг, хүүхэд асрах төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийг бүх талаар дэмжинэ.
8. Нийтийн халуун усны үйл ажиллагааг тогтмол ажиллуулах арга хэмжээ авна.
9. Зорчигч тээврийн үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, тогтмолжуулна.
10. Ундны усны стандарт шаардлага хангасан цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулна.
11. Өвсний фондыг түшиглэн малын тэжээл бэлтгэх цех байгуулах хувийн хэвшлийн байгууллагын санаачилгыг дэмжинэ.
12. Хүлэмжийн аж ахуй эрхэлж нарийн ногоо, жимс жимсгэнэ тариалж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
13. Бог, бод малын үйлдэр угсааг сайжруулах, цөм сүрэг бүрдүүлэх.
14. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн болон бусад үйлдвэр, байгууллагыг түшиглэн бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэрлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ
15. Сэргээгдэх эрчим хүч ашиглан малчдын ус гараар татах аргыг хялбар болгоно.



16. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, празит өвчнийг бууруулж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлнэ.
17. Уст цэгийн тоог нэмэгдүүлж, бэлчээрийн усан хангамжийг сайжруулна.
18. Дөчөөс дээш насныхан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
19. Жижиг дунд үйлдвэр, хоршоо, нөхөрлөл эрхэлж буй иргэд, хувийн хэвшлийнхнийг нэгдсэн бодлогоор дэмжиж, санхүүгийн чадавхтай болгох нөхцлийг бүрдүүлнэ.
20. Суманд шилмэл малын үзэсгэлэн зохион байгуулж, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулах бодлого хэрэгжүүлнэ.
21. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
22. Хөдөө аж ахуйн хоршоодын үйл ажиллагааг дэмжинэ.
23. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор "Орлоготой залуу" дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
24. "Мобайл технологи" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
25. Спортын олон төрөлт тэмцээн уралдаан зохион байгуулна.

2. ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 Суманд инженерийн шугам сүлжээ бүхий орон сууц барина.
- 2.2 Төвлөрсөн уурын зуух барьж, нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугам тавина.
- 2.3 Нийтийн эзэмшлийн зам талбайг засаж тохижуулна.
- 2.4 Сумын төвийн гудамж талбайг ээлж дараатайгаар гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 2.5 Ингэний аж ахуй байгуулах санаачлагыг бодлогоор дэмжинэ.
- 2.6 Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэл, угаалга хийх зориулалтын ДУК автомашинтай болно.
- 2.7 Биеийн тамир спортын төв байгуулна.

ГУРАВ. БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БОДЛОГО

- 3.1. Орон нутагт байгаль орчныг хамгаалах иргэдийн болон Төрийн бус байгууллагын үүсгэл санал санаачилгыг бүх талаар дэмжин, тэдэнтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах бодлого баримтлана.
- 3.2 Уст цэгийн тоог нэмэгдүүлж, бэлчээрийн усан хангамжийг сайжруулна.
- 3.3 Заган ой, тоорой, сухайн төглийг хамгаалах ажлыг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 3.4 Өлгий, Ганзагтын уулыг улсын тусгай хамгаалалтад авах арга хэмжээ авна.



- 3.5 Улсын болон аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, ховор ан амьтан, ургамал, түүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулна.
- 3.6 Идэвхитэн байгаль хамгаалагчийг баг бүрт ажиллуулна.
- 3.7 Сумын хэмжээнд мод тарих бүх нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

- 4.1 Иргэдийнхээ итгэл дэмжлэгийг хүлээсэн хариуцлагатай төрийн албыг бий болгоно.
- 4.2 Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид төрийн албыг төлөвшүүлнэ.
- 4.3 Аливаа төсөл, тендер шалгаруулалтыг ил тод, нээлттэй, үр өгөөжтэй болгоно.
- 4.4 Иргэдэд өдөр тутам үйлчилдэг нийтийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэд өөрсдөө үнэлдэг тогтолцоонд оруулж, хариуцлага, цалин хангамжийг ажлын үр дүнтэй уялдуулан тооцож, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 4.5 Төрийн албан хаагчдын тогтвортой ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлж, тэднийг боловсрол, мэдлэг, ур чадвар болон өөрийгөө хөгжүүлэх санал санаачлагыг дэмжинэ.
- 4.6 Замын осол аваар гарч болзошгүй газруудад таних тэмдэг байрлуулах ажлыг зохион байгуулна.
- 4.7 Хөрш зэргэлдээ сум, аймгийн удирдлагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана. Ялангуяа отор нүүдэл хийх, хадлан тэжээл бэлтгэх асуудлаар байнга холбоотой ажиллана.
- 4.8 Олон улсын төсөл хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, сургалт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

Мандах сумын Монгол Ардын Намын хорооноос дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр нь нийгмийн ардчиллын үзэл баримтлалын хүрээнд нарийн тооцоо судалгаанд тулгуурласан ба иргэн төвтэй Мандах сумыг хөгжүүлэхэд чиглэгдэж, ард иргэдийн амьдралд бодит ахиц гаргах баримт бичиг юм.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

